

Улсын бүртгэлийн
дугаар

Аравтын бүрэн
Ангиллын код

Нууцын зэрэглэл:

Төсөл гүйцэтгэх гэрээний
дугаар : Шу Дс-2019/08

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

ХИЙМЭЛ ОЮУН УХААНД СУУРИЛСАН ДРОНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ

Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацийн тэтгэлэгт төсөл
2019-2022

Төслийн удирдагч:

Ц.Тэнгис - доктор (Ph.D), ШУТИС, МХТС-ийн багш

Санхүүжүүлэгч байгууллага:

БСШУСЯ-ны Шинжлэх ухаан, технологийн сан

Захиалагч байгууллага:

БСШУСЯ-ны Шинжлэх ухаан, технологийн бодлогын
газар

Улаанбаатар хот

2022 он

Улсын бүртгэлийн
дугаар

Аравтын бүрэн
Ангиллын код

Нууцын зэрэглэл:

Төсөл гүйцэтгэх гэрээний
дугаар : Шу Дс-2019/08

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

ХИЙМЭЛ ОЮУН УХААНД СУУРИЛСАН ДРОНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ

Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацийн тэтгэлэгт төсөл
2019-2022

Төслийн удирдагч:	Ц.Тэнгис - доктор (Ph.D), ШУТИС, МХТС-ийн багш
Төслийн зөвлөх:	А.Батмөнх – доктор (Ph.D), ШУТИС, МХТС-ийн профессор
Төслийн гүйцэтгэгч:	Л.Үүрцайх – ШУТИС, МХТС-ийн докторант Г.Бат-Эрдэнэ - ШУТИС, МХТС-ийн докторант Г.Эрхэмбаяр - ШУТИС, МХТС-ийн бакалавр
Санхүүжүүлэгч байгууллага:	БСШУСЯ-ны Шинжлэх ухаан, технологийн сан
Захиалагч байгууллага:	БСШУСЯ-ны Шинжлэх ухаан, технологийн бодлогын газар
Гүйцэтгэгч байгууллага:	ШУТИС, Мэдээлэл, Холбооны Технологийн Сургууль. 13341 Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, Утас: 70151333, Цахим хаяг: www.sict.edu.mn ;

Реферат

Өнөө үед робот системд олон төрлийн удирдлагын аргыг хэрэглэж байгаа боловч робот бие даан мэдлэг олж авах чадвартай алгоритмыг нэлээд эрчимтэй хэрэглэдэг болоод байна. Тус судалгаагаар нэг сэнст, хоёр сэнст, дөрвөн сэнст тогтворгүй системийн загварыг бодитоор бүтээсэн ба машин сургалтын регресс, ангилал, нейрон сүлжээ болон бататган сургалтын алгоритмуудыг хэрэглэн тогтворжуулах машин сургалтын аргуудыг боловсруулахад оршино. Дээрх машин сургах аргууд дээр тулгуурласан математик загварыг бодит бүтээл болгож, уг бүтээлээ байнгын хэрэглээ, сургалтад нэвтрүүлэх нь онолын мэдлэгийг практикт хэрэгжүүлэх лабораторийн орчин үүсгэх, цаашлаад уг бүтээлийг хэрэгжүүлэхэд олж авсан мэдлэг нь өөр олон төрлийн бүтээл хийх суурь болсон юм. Машин сургах аргаар роботын тэнцвэржүүлэх алгоритмуудыг хэрэгжүүлсэн. Бодит байдлаар хэрэгжүүлсэн нь амжилттай болсон.

Түлхүүр үг: машин сургалт, робот, удирдлага, дөрвөн сэнст, нисдэг тэрэг, хөдөлгүүр, контроллёр

Гүйцэтгэгчдийн нэрийн жагсаалт

№	Овог нэр	Ажлын газар	Мэргэжил	Гүйцэтгэх үүрэг
1	Ц.Тэнгис	ШУТИС, МХТС	Компьютерын удирдлагатай систем (Ph.D)	Төслийг ерөнхийд нь удирдаж, чиглэл өгнө, асуудал гарвал шийднэ. Техник хангамж болон программ хангамжийн шийдэл дээр
2	А.Батмөнх	ШУТИС, МХТС	Техник хангамж (Ph.D)	Хиймэл оюун ухааны математик загварыг гаргах
3	Л.Үүрцайх	ШУТИС, МХТС	Компьютерын удирдлагатай систем (Ph.D)	Хиймэл оюун ухааны математик загварыг гаргах, угсралт, туршилт, тооцоолол
4	Г.Бат-Эрдэнэ	АШУҮИС-ИЙН СУВИЛАХУЙН СУРГУУЛЬ	Физикч. Электроникч	Хиймэл оюун ухааны математик загварыг гаргах, угсралт, туршилт, тооцоолол
5	Г.Эрхэмбаяр	ШУТИС, МХТС	Электроник	Угсралт, туршилт, тооцоолол

Төслийн календарчилсан төлөвлөгөө

Дд	Төслийн хүрээнд гүйцэтгэх тодорхой үе шатны ажлын нэр	Эхлэх дуусах хугацаа (Он, сар)	Тухайн шатны үр дүн
Эхний үе шат			
1	Системд шаардлагатай сэлбэг хэрэгслийг судлан худалдан авах	2019. 6. 01 ~ 2019. 9. 01	Дөрвөн сэнст, удирдлагын хавтан, тэжээлийн блок, мэдрүүрийн хэсэг
2	Reinforcement аргын судалгаа, түүнийг дроны хэрэглээнд буулгах симуляци	2019. 06. 01 ~ 2020. 06. 01	Reinforcement аргын симуляци, математик загвар
3	Дроны техник хангамжийн гүйцэтгэл, сургалтын өгөгдөл цуглуулах аргачлал боловсруулах	2019. 12. 01 ~ 2020. 06. 02	Анхны туршилтын загвар
Эцсийн үе шат			
1	Модулийн болон удирдлагын программ хангамжид сайжруулалт хийх	2020. 06. 02 ~ 2020. 09. 01	Хиймэл оюун ухаанд суурилсан дроны удирдлагын программ хангамжид сайжруулалт хийж дуусна
2	Нэгдсэн системийн туршилт	2020. 06. 01 ~ 2021. 1. 01	Системийн нэгдсэн туршилтыг хийж үр дүнг гаргана
3	Үр дүнг хэлэлцэж тайлан боловсруулна	2020. 09. 02 ~ 2021. 1. 01	Үр дүнгийн тайланг хүлээлгэн өгнө

Төслийн санхүүжилтийн задаргаа

Огноо	Санхүүжилтийн задаргаа /мян.төгрөг/				Нийт дүн /мян.төг/
	Гэрээт ажилтнуудын ажлын хөлс	Эрдэм шинжилгээний зардал	Томилолт	Хяналтын зардал /1%/	
2019	600.0	3,500.0	850.0	50.0	5000.0
2022	600.0	3,500.0	850.0	50.0	5000.0
Дүн	1,200.0	7,000.0	1,700.0	100.0	10,000.0

Товчилсон үгийн тайлбар

CPU	Central Processing Unit
3D	Three Dimensional
2D	Two Dimensional
DOF	Degrees Of Freedom
FOV	Field Of View
GPS	Global Positioning System
SAD	Sum of Absolute Differences
SSD	Sum of Squared Differences
MAV	Micro Aerial Vehicle
UAV	Unmanned Aerial Vehicle
SS	State Space
PID	Proportional Integral Derivative
CV	Computer Vision
ESC	Electron Speed Controller
MEMS	Micro Electro Mechanical Systems
VTOL	Vertical Take Off and Landing
PWM	Pulse Width Modulation

Гарчиг

Реферат.....	2
Төсөлд оролцогч талуудын мэдээлэл.....	2
Төслийн календарчилсан төлөвлөгөө.....	3
Төслийн санхүүжилтийн задаргаа	3
Товчилсон үгийн тайлбар.....	4
1. Оршил.....	11
1.1 Төслийг гүйцэтгэх үндэслэл, шаардлага.....	7
1.2 Судалгааны арга зүй.....	7
1.3 Төслийн эцсийн үр дүн.....	8
1.4 Төслийн үр дүнгийн шинэлэг буюу дэвшилттэй тал.....	8
1.5 Төслийн эдийн засаг, шинжлэх ухаан, нийгмийн ач холбогдол.....	8
1.6 Хэвлүүлсэн өгүүлэл.....	9
2. Төслийн судалгаа ба гүйцэтгэл.....	10
2.1 Олон гишүүнт функцийг машин сургалтын аргаар үүсгэх замаар нэг сэнст дүүжингийн тэнцвэржилтийг сайжруулах нь.....	11
2.1.1 Туршилтын үр дүн.....	16
2.1.2 Дүгнэлт.....	17
2.2 Дүүжингийн системийн тэнцвэржилтэд шийдвэрийн хилийг ашиглах боломжийн судалгаа.....	17
2.2.1 Ангиллын арга ба шийдвэрийн хил.....	19
2.2.2 Шийдвэрийн хилийг тодорхойлох нь.....	21
2.2.3 Параметрийг тодорхойлох буюу градиентын бууралт	22
2.2.4 Туршилтын үр дүн.....	23
2.2.5 Дүгнэлт.....	23
2.3 Дөрвөн сэнстийн тэнцвэржилтийг машин сургалтын бататган сурах аргаар шийдэх нь.....	24
2.3.1 Бататган сургах арга.....	24
2.3.2 Системийн загварт бататган сургах аргыг нэвтрүүлэх нь.....	26
2.3.3 Туршилт ба үр дүн.....	29
2.3.4 Дүгнэлт.....	33
2.4 Нейрон Сүлжээнд Суурилсан Дөрвөн Сэнстийн Удирдлага.....	34
2.4.1 Дөрвөн сэнстийн математик загвар.....	35
2.4.2 ПИД удирдлагын систем.....	37
2.4.3 Санал болгож буй нейрон сүлжээний загвар.....	39
2.4.4 Туршилтын үр дүн.....	41

2.4.5 Дүгнэлт.....	45
3. Төслөөс үүссэн бусад судалгааны ажлууд.....	45
3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцрийн хөгжүүлэлт.....	45
3.1.1 Туршилтын үр дүн.....	50
3.1.2 Дүгнэлт.....	52
3.2 Stereo хараа дээр тулгуурласан дөрвөн сэнстийн тогтворжуулах удирдлага.....	52
3.2.1 Математик загвар ба дизайн.....	54
3.2.2 Дөрвөн сэнстийн төлөвийн орны туйлыг байршуулах нь.....	56
3.2.3 Дүгнэлт.....	58
3.3 Олон гишүүнт функцийн коэффициентийг машин сургалтаар үүсгэн монгол улсын ирэх жилүүдийн эрчим хүчний хэрэглээг таамаглах нь.....	58
4. Төслөөр гарсан үр дүнгүүд.....	61
4.1 Дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл.....	62
4.1.1 Төслөөс үүссэн бусад судалгааны өгүүлэл.....	67
4.2 Гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл.....	68
4.3 Дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл.....	72
4.4 Гадаадын эрдэм шинжилгээний хуралд илтгэл.....	73
4.5 Биет бүтээлүүд.....	75
4.6 Зохиогчийн эрх.....	79
4.7 Боловсролын хөтөлбөр.....	79
4.8 Эшлэл.....	80
4.9 Бакалавр, магистрын сургалт.....	81
4.10 Олон нийтэд таниулан сурталчилсан ажил.....	81
4.11 Сургалтууд.....	83
5. Төслийн дүгнэлт.....	86
Талархал.....	88
Ашигласан бүтээлийн жагсаалт.....	89
Хавсралт.....	92

1. Оршил

Хиймэл оюун ухааны хөгжил жилээр биш, сараар, бараг өдрөөр улам бүр урагшилсаар байна. Хиймэл оюун ухааны дэвшлийг аж үйлдвэрт нэвтрүүлснээр бүтээмж их хэмжээгээр нэмэгдэх болсон.

1.1 Төслийг гүйцэтгэх үндэслэл, шаардлага

Түүнчлэн Accenture-аас гаргасан тайланд хиймэл оюун ухааныг аж үйлдвэрийн салбартаа ашиглаж эхэлсэн өндөр хөгжилтэй 12 орны эдийн засгийн өсөлт 2035 он гэхэд хоёр дахин нэмэгдэх хандлагатай байна.

Өнөөдөр, техникийн өндөр хөгжилтэй улс орнуудад, хиймэл оюун, хүн төрхт робот чиглэлийн судалгааны ажлууд өдрөөс өдөрт хүрээгээ тэлсээр байна. Роботын судалгаанд сүүлийн хэдэн арван жилийн турш ахиц дэвшил харагдаж байгаа хэдий ч роботууд нь үйлдвэрлэлийн хэрэглээний хүрээнээс төдийлөн хальж гарч чадаагүй л байна. Гэсэн хэдий ч зарим төрлийн роботууд хүний өдөр тутмын амьдралд оролцож, хүнтэй зэрэгцэн оршиж, тэдний амьдралд тодорхой хэмжээгээр тусалж эхлээд байгаа билээ. Хүнд аюултай орчинд бие даан ажиллах чадвар бүхий роботуудыг ашиглан судалгаа тандалтын туршилтуудыг хийхийн зэрэгцээ цэрэг зэвсэг, тагнуул, терроризмын эсрэг роботын технологийг өргөнөөр хэрэглэж эхлээд байна. Газраар явдаг, өөрөөр хэлбэл, 2 хэмжээст хөдөлгөөнтэй роботын хувьд саад тойрох замын төлөвлөлтийг нэлээд сайн судалсан бол 3D орчинд зам төлөвлөх, саад тойрох зэрэг асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй л байна. Өнөө үеийн роботын технологи, хиймэл оюун ухаан болон бусад нэмэлт технологиудтай хавсран улам илүү сонирхол татсан, судалгааны томоохон орчныг үүсгээд байгаа юм.

1.2 Судалгааны арга зүй

Бидний судалгааны ажлын үндсэн зорилго нь 4 сэнст нисдэг тэрэг буюу дроны тэнцвэржилтийг хиймэл оюун ухаанд суурилан удирдах судалгааг хийсэн. Энэхүү судалгааг хийснээр дэлхий дахины судалгааны ажилтай хөл зэрэгцэн алхах боломжтой юм.

Бид өмнөх судалгаанд дөрвөн сэнстийн удирдлагыг PID болон төлөвийн гэдрэг холбоотой удирдлагын аргаар тэнцвэржүүлэн удирдсан билээ. Дээрх дурдсан аргууд классик удирдлагын аргуудад тооцогддог юм. Энэхүү удирдлагын аргууд нь математик тооцоолол ихтэй, дөрвөн сэнстийн математик загварыг нарийн тооцоолох шаардлагатай байдаг. Бид дроны тэнцвэржилтэд Регресс, Ангилал, Нейрон сүлжээ болон Reinforcement хиймэл оюуны аргыг хэрэглэн хөгжүүлэхэд оршино. Энэхүү удирдлагын арга нь хурдатгал болон гироскоп мэдрүүрийн түүхий өгөгдлөөс мэдлэгийг гарган авах замаар дроны тэнцвэржилтийг хийнэ.

Reinforcement аргыг роботын технологид өргөнөөр хэрэглэж эхэлж байгаа ба энэхүү арга нь систем өөрийн гаргаж буй үйлдлээс туршлагыг бий болгосноор мэдлэгийг олж авдаг.

1.3 Төслийн эцсийн үр дүн:

Энэхүү төслийн ажлын эцсийн үр дүнд хиймэл оюун ухаанд суурилсан дөрвөн сэнстийн удирдлага бий болсон. Мөн дараах үр дүнгүүд гарсан:

- ❖ Дөрвөн сэнстэд тохирох хиймэл оюун ухааны арга болох Регресс, Ангилал, Нейрон сүлжээ болон Reinforcement аргуудын математик загвар гарсан.
- ❖ Хиймэл оюун ухаанд суурилсан дөрвөн сэнстийн техник хангамжийг шийдсэн
- ❖ Хиймэл оюун ухаанд суурилсан дөрвөн сэнстийн программ хангамжийг шийдсэн
- ❖ Гадаадын сэтгүүлд өгүүлэл, дотоодын сэтгүүлд өгүүлэл тус тус хэвлүүлсэн
- ❖ Ахисан төвшинд орох хичээлийн хөтөлбөр бий болсон

1.4 Төслийн үр дүнгийн шинэлэг буюу дэвшилттэй тал

Энэхүү төслийн шинэлэг тал нь хиймэл оюун ухаанд суурилсан дөрвөн сэнст юм. Энэхүү дэвшилтэд удирдлагын аргыг нутагшуулснаар зөвхөн дөрвөн сэнстээс гадна аж үйлдвэрийн салбарт өргөнөөр нэвтрүүлэх боломжтой юм.

1.5 Төслийн эдийн засаг, шинжлэх ухаан, нийгмийн ач холбогдол

Төсөл хэрэгжсэнээр хиймэл оюун ухаанд суурилсан удирдлагын аргыг нутагшуулах боломж бий болж байна. Хиймэл оюун ухаан хүний амьдралыг хөнгөвчлөхөөс гадна аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, хөгжлийг хурдасгах түлхүүр болно. Бидний судалгааны ажлын үр дүнгээс ахисан төвшний хичээлийн хөтөлбөр бий болсноор олон оюутан залуучуудад хиймэл оюун ухааны талаарх мэдлэгийг хүргэх зам нээгдэнэ.

1.6 Хэвлүүлсэн өгүүлэл

Бид дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд нийт **8** өгүүлэл хэвлүүлсэн болно.

- ❖ Ц.Тэнгис, А.Батмөнх, Л. Үүрцайх “Control of Single Propeller Pendulum with Supervised Machine Learning Algorithm” Khureltogoot 2019
- ❖ Ц.Тэнгис, А.Батмөнх, Г. Эрхэмбаяр “Дөрвөн сэнстийн тэнцвэржилтийг машин сургалтын бататган сурах аргаар шийдэх нь”, ШУТИС, МХТС-ийн эрдэм шинжилгээний эмхэтгэлд, 2020
- ❖ Ц.Тэнгис, А.Батмөнх “Дөрвөн сэнстийн тэнцвэржилтийг машин сургалтын бататган сурах аргаар шийдэх нь”, ММТ2020
- ❖ Ц.Тэнгис, А.Батмөнх “Neural Network-based Quadcopter Control”, Khureltogoot 2021, хуудас 110
- ❖ Ц.Тэнгис, “Нейрон Сүлжээнд Суурилсан Дөрвөн Сэнстийн Удирдлага”, ММТ2021
- ❖ Бат-Эрдэнэ, Ц.Тэнгис “Дөрвөн сэнстийн удирдлагад нейрон сүлжээний загваруудыг харьцуулан турших нь” ШУТИС-ийн эрдэм шинжилгээний эмхэтгэлд, 2021
- ❖ Бат-Эрдэнэ, Ц.Тэнгис, А.Батмөнх “Нейрон Сүлжээнд Суурилсан Дөрвөн Сэнстийн Удирдлага” Математик, тоон технологийн хуралд 2022
- ❖ Бат-Эрдэнэ, Ц.Тэнгис, Ч. Лодойравсал А.Батмөнх “Quadcopter Stabilization using Neural Network model from collected data of PID controller” ICTFocus journal, 2022

Бид гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд нийт **5** өгүүлэл хэвлүүлсэн болно.

- ❖ Tengis Ts, Uurtsaikh L, Batmunkh A, "Machine learning for stabilizing quadrotor's single-axis using classifier decision boundary", IFOST 2019
- ❖ Tengis Ts, Uurtsaikh L, Batmunkh A “ Control of seesaw balancing using decision boundary based on classification method ” International Journal of Internet, Broadcasting and Communication Vol 11, Nnumber 2, page 11
- ❖ Ts.Tengis, L. Uurtsaikh, A. Batminkh, "Balancing a seesaw with reinforcement learning", International Journal of Advanced Culture Technology Vol.8 No.4 51-57 (2020)
- ❖ Staroletov S, Tengis Ts, “Model-Driven Development Methods and Formal Verification Algorithms for Cyber-Physical Systems as Applied to System Software of Unmanned Aerial Vehicles”, Сетевое издание Совета ректоров вузов Большого Алтая, 2020
- ❖ Ts.Tengis, “Quadrotor stabilization in hovering mode based on the stereo vision”, International Conference on Electrical, Computer and Energy Technologies Journal, 2021

2. Төслийн судалгаа ба гүйцэтгэл

Машин сургалт (machine learning, ML) гэдэг нь нарийвчилсан програмчлалгүйгээр компьютер өөрөө суралцах асуудлыг судалдаг шинжлэх ухааны салбар юм [1, 2, 3, 4]. Өөрөөр хэлбэл, компьютер өөрөө түүхий өгөгдлөөс мэдлэг олж авах чадвартай болох хэрэгтэй юм. Энэхүү чадварыг machine learning буюу машины суралцах чадвар гэнэ. Машин сургалтын алгоритмыг доорх үндсэн 3 хэсэгт хуваадаг байна [1, 5, 8, 9].

- ❖ Хяналтгүй (Unsupervised)
- ❖ Хяналттай (Supervised)
- ❖ Бататган (Reinforcement)

Хяналтгүй сургалтын зорилго нь ангилаагүй буюу тэмдэггүй өгөгдөл дотроос тус өгөгдлийн далд бүтцийг хайж олоход оршдог бол хяналттай сургалтын зорилго нь ангилсан буюу тэмдэгтэй өгөгдлийг ашиглан таамаглалын функцийг тодорхойлоход оршино. Сургалтын өгөгдөл нь оролт болон гаралтын өгөгдлийн хос багцуудаас тогтдог байна.

Хяналттай сургалт нь эдгээр өгөгдөлд шинжилгээ хийж харгалзах хамаарлын функцийг үүсгэх бөгөөд энэ функцийг шинэ өгөгдлийг боловсруулахад дахин ашиглах нөхцөлийг бүрдүүлэн хамгийн оновчтой алгоритмыг үүсгэнэ. Үүний тулд тоон регрессийн тусламжтайгаар оролт болон гаралтын өгөгдлийн харилцан хамаарлыг тодорхойлох ба оролтыг хэрхэн гаралт болгон хувиргаж буй функцийг таамаглаж байдаг. Машин сургалтын алгоритм, түүний үр дүнг математикийн шинжилгээний аргын тусламжтайгаар тооцоолох боломжтой бөгөөд энэ нь компьютерын шинжлэх ухааны онолын нэгэн салбар юм [10, 11, 12, 13].


Энэхүү төслийн хүрээнд бид нэг сэнст, хоёр сэнст болон дөрвөн сэнстийн тэнцвэржилт болон удирдлагын аргыг машин сургалтаар шийдэхийг зорьсон.

Үүнд бид дараах машин сургалтын аргуудын судалгааг хийж, туршиж, нэвтрүүлсэн болно:

- ❖ Регрессийн арга
- ❖ Ангиллын арга
- ❖ Нейрон сүлжээний арга
- ❖ Бататган сурах арга

2.1 Олон гишүүнт функцийг машин сургалтын аргаар үүсгэх замаар нэг сэнст дүүжингийн тэнцвэржилтийг сайжруулах нь

Өмнөх судалгааны ажлуудаар нэг сэнст дүүжинг тодорхой өнцөгт тогтвортой барихын тулд бид PID болон төлөвийн гэдрэг холбоо бүхий удирдлагын аргуудыг тус тус хэрэглэн удирдлагыг амжилттай туршиж үзсэн болно [1-8]. Дээрх удирдлагын аргуудыг хэрэглэхдээ юуны өмнө, тухайн системийн динамик болон кинематикийн загварыг тодорхойлох шаардлагатай байдаг.



Зураг 2.1.1 Нэг сэнст дүүжингийн загвар

Зураг 2.1.1-д туршилтын загварыг харуулсан ба энд, l савлуурын төвөөс сэнст хөдөлгүүр хүрэх зай, ψ нь x тэнхлэгийн дагуу үүсэж буй өнцөг, m сэнст хөдөлгүүрийн жин, F сэнст хөдөлгүүрээс үүсэх өргөх хүч, g таталцлын хурдатгал.

Импульсийн өргөний модуляцаар (PWM) хөдөлгүүрийн эргэлтийн хурдыг удирдах ба тухайн хөдөлгүүрийн эргэлтийн хурдаас хамааран мушгих момент үүсэж дүүжинг өргөнө.

$$-lF + lmg \cos \psi = -l\ddot{\psi}lm \quad (1)$$

Энд $\ddot{\psi}$ нь өнцөг хурдатгал.


Энэхүү судалгаагаар судалж буй объектын (нэг сэнст буюу хэвтээ дүүжин Зураг 2.1.1) динамик болон кинематикийн загварын гаргалгааг үл хэрэглэх бөгөөд энэ системийн зөвхөн оролт болон гаралтын утгуудыг ашиглан хяналттай машин сургалт дээр суурилсан бодит удирдлагын системийг бүтээж компьютерыг сургах аргын туршилтуудыг хийв.



Зураг 2.1.2 Нэг сэнст дүүжин. Баруун талаас дүүжингийн анхны байрлал, дүүжин 45° байрлалд, 90° байрлалд, 110° байрлалд

Регрессийн арга болох хяналттай машин сургалтын гол санаа нь цуглуулсан сургалтын өгөгдөлд харгалзах функцийг дүгнэх үйл ажиллагаа бөгөөд [1-5] өмнө нь тодорхойлсон сургалтын үр дүнг үүсгэж буй систем нь хэр зөв тодорхойлж суралцсан болохыг дүгнэхэд орших юм. Манай судалгааны ажлын зорилго нь нэг сэнст дүүжинг тодорхой өнцөгт тогтвортой барих удирдлага юм. Үүний тулд хөдөлгүүрийн эргэх хурдыг өөрчлөх замаар өргөх хүчийг өөрчилж дүүжингийн тогтох өнцгийг бүртгэж авснаар сургах өгөгдлийг үүсгэнэ. Ийнхүү цуглуулж авсан өгөгдлийг Хүснэгт 2.1.1-т үзүүлэв.

Сургалтын өгөгдлийн хамаарлыг Зураг 2.1.3-т үзүүлэв.



Зураг 2.1.3. Сургах өгөгдлийн хамаарлын график

Хүснэгт 2.1.1 Сургах өгөгдөл

m	x - (Өнцөг)	y- (PWM)	m	x - (Өнцөг)	y- (PWM)
1	-84.36	760	16	-69.26	850
2	-86.41	766	17	-67.14	856
3	-86.72	772	18	-64.51	862
4	-87.4	778	19	-59.92	868
5	-88.34	784	20	-57.22	874
6	-88.64	790	21	-54.76	880
7	-87.52	796	22	-51.06	886
8	-86.82	802	23	-46.15	892
9	-84.35	808	24	-42.99	898
10	-83.3	814	25	-39.4	904
11	-81.41	820	26	-32.27	910
12	-77.88	826	27	-27.05	916
13	-76.51	832	28	-22.4	922
14	-74.67	838	29	-16.65	928
15	-73.28	844	30	0	934

Энд,

m – сургалтын жишиг тоо $m=30$


x – оролтын хувьсагч

y – гаралтын хувьсагч

$(x^{(i)}, y^{(i)})$ – сургалтын жишиг


Жишээ нь, $(x^{(1)}, y^{(1)}) = (-84.36, 760)$

Өмнөх судалгаагаар хяналттай машин сургалтын алгоритмыг хэрэглэн шугам регрессийн аргыг ашиглан шулууны функцийг тодорхойлсон болно. Зураг 2.1.4-т улаан шулуунаар машин сургалтын шугам функц тодорхойлогдсон болно. Бодит туршилтын үед 0° өнцөгт тогтвортой тогтоох боломжгүй байгаа нь харагдаж байна. Мөн зарим өнцгүүдэд очиж хүрэхгүй байгаа алдаанууд гарч байгааг Зураг 2.1.4-т үзүүлэв. Үүнийг сайжруулах үүднээс олон гишүүнт функцийг тодорхойлох зорилго тавин ажиллаа.



Зураг 2.1.4. Машин сургалтын шугаман хамаарлын график

Хяналттай сургалтын арга нь дараах алгоритмын дагуу ажиллана (Зураг 2.1.5). Цуглуулсан сургах өгөгдлийг сургалтын алгоритмд оруулна. Сургалтын алгоритмын гол үүрэг нь гаралтдаа таамаглалын функцийг тодорхойлоход оршино. Таамаглалын функц нь оролтод өгөгдсөн тогтворжих өнцгийн утгыг авч тухайн өнцөгт тогтвортой барих хөдөлгүүрийн эргэлтийн хурдыг тооцоолно.



Зураг 2.1.5. Сургалтын алгоритм

Тиймээс h функц нь x -ийг y -т дүрслэн буулгах функц юм. Тухайн системийг бид шугаман бус систем гэж үзэв. Энд, h - таамаглалын функц (hypothesis).

$$h_{\theta}(x) = \theta_0 + \theta_1 x + \theta_2 x^2$$

Энд, $h_{\theta}(x)$ – таамаглалын функц, $\theta_0, \theta_1, \theta_2$ – параметрууд тус тус болно.

Бид $\theta_0, \theta_1, \theta_2$ параметруудийг тодорхойлох зорилготой туршилтыг явуулсан. Дээрх параметруудийг тодорхойлохын тулд сургах өгөгдлүүдтэй хамгийн ойр дайрч гарах шулууныг тодорхойлно. Үүний тулд таамаглалын функц болон гаралтын утгын ялгавар хамгийн бага байх шаардлагатай юм.

$$h_{\theta}(x^{(i)}) - y^i$$

Тухайн системийн үнэлгээний функц J -ийг (2) илэрхийллээр тодорхойлно.

$$J(\theta_0, \theta_1, \theta_2) = \frac{1}{2m} \sum_i^m (h_{\theta}(x^{(i)}) - y^{(i)})^2 \quad (2)$$

Өөрөөр хэлбэл, $J(\theta_0, \theta_1, \theta_2)$ функцийн минимум $\theta_0, \theta_1, \theta_2$ тодорхойлоход оршино.

$$\min_{\theta_0, \theta_1, \theta_2} J(\theta_0, \theta_1, \theta_2) \quad (3)$$

Таамаглалын функцийг томъёолбол,

$$h_{\theta}(x) = \theta_0 + \theta_1 x + \theta_2 x^2 \quad (4)$$

Тус функцийн параметрууд нь $\theta_0, \theta_1, \theta_2$ байна.

Үнэлгээний функцийн параметруудийн минимум утгыг тодорхойлох шаардлагатай болохыг дээр авч үзсэн. Үүний тулд градиент бууралтын алгоритмыг ашиглана.

Эхлээд $\theta_0, \theta_1, \theta_2$ параметруудийг дурын байдлаар сонгож авна. Ихэвчлэн $\theta_0 = 0$, $\theta_1 = 0$, $\theta_2 = 0$ байхаар сонгож авдаг ба $J(\theta_0, \theta_1, \theta_2)$ функцийн утга багасах байдлаар параметруудийн утгыг өөрчилнө. Програмын алгоритм хэлбэрээр дүрсэлбэл,

Давхцал үүстэл давт()

$$\{\theta_j := \theta_j - \alpha \frac{\partial}{\partial \theta_j} J(\theta_0, \theta_1, \theta_2)\} \quad (5)$$

Энд, $j = 0, j = 1, j = 2$ байна.

Давталт хийх явцад параметруудийн өгөгдлийг нэгэн зэрэг өөрчлөх шаардлагатай.

for (;)

$$\begin{aligned} \{t\theta_0 &:= \theta_0 - \alpha \frac{\partial}{\partial \theta_0} J(\theta_0, \theta_1, \theta_2) \\ t\theta_1 &:= \theta_1 - \alpha \frac{\partial}{\partial \theta_1} J(\theta_0, \theta_1, \theta_2) \\ t\theta_2 &:= \theta_2 - \alpha \frac{\partial}{\partial \theta_2} J(\theta_0, \theta_1, \theta_2) \\ \theta_0 &:= t\theta_0 \\ \theta_1 &:= t\theta_1 \\ \theta_2 &:= t\theta_2 \} \end{aligned} \quad (6)$$

Энд, α нь сурах хурд юм. α -н утга бага үед сурах хурд удаан байна. Харин α хэт их үед үсрэлтүүд үүссэний улмаас параметрийн минимум утгыг олох боломжгүй юм.

Параметрийн минимум утгыг олохын тулд үнэлгээний функцээс хэсэгчилсэн уламжлалыг $\frac{\partial}{\partial \theta_j} J(\theta_0, \theta_1, \theta_2)$ авна.

$$\frac{\partial}{\partial \theta_j} J(\theta_0, \theta_1, \theta_2) = \frac{\partial}{\partial \theta_j} * \frac{1}{m} \sum_{i=1}^m (h_{\theta}(x^{(i)}) - y^{(i)})^2 \quad (7)$$

$$\frac{\partial}{\partial \theta_j} J(\theta_0, \theta_1, \theta_2) = \frac{\partial}{\partial \theta_j} \frac{1}{m} \sum_{i=1}^m (\theta_0 + \theta_1 x^{(i)} + \theta_2 x^{2(i)} - y^{(i)})^2 \quad (8)$$

$$\theta_0: \frac{\partial}{\partial \theta_0} J(\theta_0, \theta_1, \theta_2) = \frac{1}{m} \sum_{i=1}^m (h_\theta(x^{(i)}) - y^{(i)}) \quad (9)$$

$$\theta_1: \frac{\partial}{\partial \theta_1} J(\theta_0, \theta_1, \theta_2) = \frac{1}{m} \sum_{i=1}^m (h_\theta(x^{(i)}) - y^{(i)}) (x^{(i)}) \quad (10)$$

$$\theta_2: \frac{\partial}{\partial \theta_2} J(\theta_0, \theta_1, \theta_2) = \frac{1}{m} \sum_{i=1}^m (h_\theta(x^{(i)}) - y^{(i)}) (x^{2(i)}) \quad (11)$$

Программын алгоритмын ажиллагааг Arduino дээр дараах байдлаар бичигдсэн.

2.1.1 Туршилтын үр дүн

Зураг 2.1.1-д үзүүлсэн нэг сэнст дүүжин нь -90° - $+10^\circ$ завсарт савлана. Бид сургалтын 30 өгөгдлийг цуглуулсан ба контроллёр дээр тооцоолол хийх замаар параметруудийг тодорхойлов. Тооцооллыг 8 MHz давтамжид ажилладаг Atmega32 контроллёр дээр гүйцэтгэсэн ба сурах хурд $\alpha = 0.02$ байхаар сонгосон болно. Сургалтын үр дүнд дараах параметруудийг тооцоолов.

$$\theta_0 := 926,67$$


$$\theta_1 := -0,4046$$

$$\theta_2 := -0,0229$$

Эндээс таамаглалын функц нь

$$h_\theta(x) = 926.67 - 0.4046x - 0.0229x^2$$

гэж гарна. Тооцоолсон шугаман хамаарлын үр дүнг Зураг 2.1.6-д ногоон шулуунаар дүрслэв.



Зураг 2.1.6. Сургалтын үр дүнгээс үүссэн хамаарлын шулуун Алдаа буюу зөрүүний утга буурсан болохыг Зураг 2.1.6-с харж болно.

2.1.2 Дүгнэлт

Нэг сэнст тогтворгүй дүүжингийн системийг хяналттай сургалтын аргаар сургаж туршилтыг амжилттай явуулав. Сурах хурд болох α -г туршилтаар тодорхойлсон бөгөөд $\alpha=0.02$ байх нь оновчтой байна. Контроллёрын сонголтоос дараах 2 зүйл хамаарч байна.

Нэгдүгээрт, санах ойн хэмжээнээс хамаарч сурах өгөгдлийн хэмжээ хязгаартай байна. Сурах өгөгдлийн тоо их байх тусам алдаа буурах магадлал өндөр байна. Бутархайн тоон утга ашиглах үед регистрүүдийн утга дүүрч халилт үүсэж байв.

Хоёрдугаарт, параметрүүдийг тооцоолох хугацаа контроллёрын ажиллах хурднаас хамаарах тул манай туршилтад параметрүүдийг тооцоолоход ойролцоогоор 90 секунд зарцуулж байв.


Өмнөх туршилтаар шулууны функцийг ашигласан тул анхны муруй болон шулууны байршлын зөрүүнээс болж зарим өнцгийн утгад эс хүрэх эсвэл давж гарах тохиолдол ажиглагдаж байсныг 2-р эрэмбийн олон гишүүнтийн функцийг хэрэглэснээр дээрх алдааг бууруулж чадлаа.

Сурах алгоритмыг суулгасан энэ систем нь тэжээлийн өөр өөр хүчдэлийн утгуудад, түүнчлэн өөр өөр жинтэй ачааны утгад дахин суралцах замаар дүүжинг өгөгдсөн өнцөгт тогтвортой барьж чадаж байв.

Тухайн системийн кодыг энэхүү судалгаанд дэлгэрэнгүй оруулж өгснөөр машин сургалтын аргыг сонирхож буй залуусын цаашдын судалгааны ажилд дэм болно гэж найдаж байна.

2.2 Дүүжингийн системийн тэнцвэржилтэд шийдвэрийн хилийг ашиглах боломжийн судалгаа

Өмнөх судалгааны ажлуудаар хоёр сэнст дүүжинг тодорхой өнцөгт тогтвортой барихын тулд ПИД (PID) болон төлөвийн гэдрэг холбоо бүхий удирдлагын аргуудыг тус тус хэрэглэн удирдлагыг амжилттай туршиж үзсэн билээ [12-17, 31, 42]. Удирдлагын дээрх аргуудыг хэрэглэхдээ юуны өмнө, тухайн системийн динамик болон кинематикийн математик загварыг тодорхойлох шаардлагатай байдаг. Дээрх сонгодог аргаар энэ системийн динамикийн илэрхийллийн гаргалгааг хэрхэн хийж буйг жишээ болгон доор харуулав.



Зураг 2.2.1. Хоёр сэнст дүүжингийн загвар

Зураг 2.2.1-д туршилтын загварыг харуулсан ба энд, l_1 , l_2 савлуурын төвөөс сэнст хөдөлгүүр хүрэх зай, ψ нь x тэнхлэгийн дагуу үүсэж буй өнцөг, m_1 , m_2 сэнст хөдөлгүүрийн жин, F_1 , F_2 сэнст хөдөлгүүрээс үүсэх өргөх хүчнүүд, g таталцлын хурдатгал. Энд m_1 болон m_2 массууд ялгаатай, мөн сэнсний дэлбээний хэмжээ нь ялгаатай тул F_1 , F_2 өргөх хүчнүүд харилцан өөр байна. Үүнээс дүгнэхэд энэ систем нь тогтворгүй, тэнцвэргүй систем болох нь тодорхой юм.

Импульсийн өргөний модуляцаар (PWM) сэнс бүхий хөдөлгүүрийн эргэлтийн хурдыг удирдах ба тухайн хөдөлгүүрийн эргэлтийн хурднаас хамааран мушгих момент үүсэж дүүжинг өргөнө.

Системийн математик загварыг доорх илэрхийллээр үзүүлэв.

$$-l_1 m_1 g \cos \psi - l_2 m_2 g \cos \psi + l_1 F_1 - l_2 F_2 = -l_1^2 \ddot{\psi} m_1 - l_2^2 \ddot{\psi} m_2 \quad (1)$$

$$(l_1 m_1 - l_2 m_2) g \cos \psi + l_1 F_1 - l_2 F_2 = -(l_1^2 m_1 + l_2^2 m_2) \ddot{\psi}$$

$$l_m = l_1^2 m_1 + l_2^2 m_2$$

$$\ddot{\psi} = \frac{l_2}{l_m} F_2 - \frac{l_1}{l_m} F_1 - \frac{l_1 m_1 - l_2 m_2}{l_m} g \cos \psi \quad (2)$$

Энд $\ddot{\psi}$ нь өнцөг хурдатгал.

Дээрх системийн тэнцвэрийг хангах PID эсвэл төлөвийн удирдлагын аргыг хэрэглэхийн тулд дүүжингийн мөрнүүдийн урт (l_1 , l_2), жингийн хэмжээ (m_1 , m_2), өргөх хүчнүүдийг (F_1 , F_2) нарийн тодорхойлж, гэдрэг холбоо үүсгэх замаар удирдана.

Энэхүү судалгаагаар судалж буй объектын (Зураг 2.2.1) хөдөлгөөнийг хяналттай машин сургалтын аргаар удирдах тул тус системийн динамик болон кинематикийн загварыг үл хэрэглэнэ. Харин энэ систем нь туршилт хийх явцад цуглуулсан оролт

болон гаралтын утгуудын мэдээлэл дээр тулгуурлан машин сургалтын ангиллын аргаар тэнцвэргүй бодит системийг тэнцвэржүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх юм. Зураг 2.2.2-т бодит загварыг харуулав.



Зураг 2.2.2 Хоёр сэнст дүүжин 0^0 байрлалд

2.2.1 Ангиллын арга ба шийдвэрийн хил

Манай судалгааны ажлын зорилго нь ангиллын аргаас гарган авсан шийдвэрийн хилийг ашиглан хоёр сэнст дүүжинг тодорхой өнцөгт тогтвортой барих удирдлагыг хэрэгжүүлэхэд оршино. Энэ удаа бид зөвхөн хоёр утга $(0, 1)$ -ыг авах боломжтой хоёртын ангиллын асуудалд анхаарлаа хандуулах юм. Үүний тулд хөдөлгүүрүүдийн эргэх хурдыг өөрчлөх замаар өргөх хүчийг өөрчилж дүүжингийн тогтох өнцөг ψ -г бүртгэж авснаар сургах өгөгдлийг үүсгэнэ. Хөдөлгүүрийн эргэлтийн хурднаас үүсэх F_2 хүчийг сургалтын оролтын x_1 , харин F_1 хүчний утгыг сургалтын оролтын x_2 багцад бүртгэж авна.

$F_2 > F_1$ байх үед ψ өнцгийн утга эерэг байх ба үүнийг сургалтын гаралтын утга $y=1$ байхаар бүртгэх ба харин $F_2 < F_1$ байх үед ψ өнцгийн утга сөрөг тэмдэгтэй байна. Үүнийг сургалтын гаралтын утга $y=0$ гэж тэмдэглэж авна (Хүснэгт 2.2.1).


Хүснэгт 2.21. Сургах өгөгдөл

№	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	:	110
x_1	830	840	850	860	870	880	890	840	850	860	870	880	890	840	830	780	790	800	810	820	:	880
x_2	800	800	800	800	800	800	800	810	810	810	810	810	810	820	800	850	850	850	850	850	:	810
y	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0	0	0	0	0	:	1

Энд,


m – сургалтын нийт жишиг тоо $m=110$, x_1 , x_2 – оролтын хувьсагч, y –гаралтын хувьсагч, $(x^{(i)}, y^{(i)})$ – сургалтын i дэх жишиг хос утга. Жишээ нь, $(x^{(1)}, y^{(1)}) = (830, 800, 1)$

Сургалтын өгөгдлийн хамаарлыг Зураг 2.2.3-т үзүүлэв. Улаан дугуй дүрсээр $y=1$ байх үеийн утгуудыг, цэнхэр дугуй дүрсээр $y=0$ байх үеийн утгуудыг дүрслэв.



Зураг 2.2.3. Сургах өгөгдлийн хамаарлын график


Ангиллын аргыг хэрэглэн улаан болон цэнхэр дүрсүүдийг зааглаж буй шулууныг тодорхойлох боломжтой юм. Уг шулууныг шийдвэрийн хил (Зураг 2.2.4) гэх ба тухайн шийдвэрийн хил дээр манай систем $\psi=0$ өнцөгт тэнцвэртэй орших болно.



Зураг 2.2.4. Шийдвэрийн хил

2.2.2 Шийдвэрийн хилийг тодорхойлох нь

Хяналттай сургалтын ангиллын арга нь дараах алгоритмын дагуу ажиллана (Зураг 2.2.5). Цуглуулсан сургалтын өгөгдлийг сурахуйн алгоритмд оруулах ба сурахуйн алгоритмын үндсэн үүрэг нь дээрх хилийг тодорхойлж буй гаралтын таамаглалын функцийг коэффициентуудыг тодорхойлоход оршино. Таамаглалын функцээс шийдвэрийн хилийг тодорхойлж $\psi=0$ өнцөгт тогтвортой барих сэнст хөдөлгүүрүүдийн эргэлтийн хурдыг тооцоолно.



Зураг 2.2.5. Сургалтын алгоритм

Эндээс харахад, таамаглалын h функц нь x -ийг y -т дүрслэн буулгах функц юм. Энд, h -г таамаглалын функц (hypothesis) гэх ба бид доорх нөхцөлийг хангахаар тооцоолно.

$$0 \leq h_{\theta}(x) \leq 1$$

Дээрх нөхцөлийг хангахын тулд сигмоид g – функцийг доорх байдлаар хэрэглэнэ.

$$h_{\theta}(x) = g(\theta^T x) \quad (3)$$

$$z = \theta^T x = \theta_0 + \theta_1 x_1 + \theta_2 x_2 \quad (4)$$

$$h_{\theta}(x) = g(z) = \frac{1}{1+e^{-z}} = \frac{1}{1+e^{-\theta^T x}} \quad (5)$$

$g(z)$ функц нь дурын бодит тоог $(0, 1)$ интервалд буулгах ба ингэснээр дурын үнэлэгдсэн функцийг ангилалд илүү тохиромжтой функц болгон хувиргадаг байна. Ингэснээр, $h_{\theta}(x)$ нь гаралт 1 байх үеийн магадлалыг өгнө.

$$h_{\theta}(x) = P(y = 1|x; \theta) = 1 - P(y = 0|x; \theta)$$

Энд, $h_{\theta}(x)$ – таамаглалын функц, $\theta_0, \theta_1, \theta_2$ – энэ функцийг параметрууд тус тус болно.

Дискрет 0 эсвэл 1 ангиллыг авахын тулд бид таамаглалын функцийг гаралтыг дараах байдлаар хөрвүүлж болно:

$$h_{\theta}(x) \geq 0,5 \text{ энд } y = 1$$

$$h_{\theta}(x) < 0,5 \text{ энд } y = 0$$

Манай зорилго нь $\theta_0, \theta_1, \theta_2$ параметруудийг тодорхойлох туршилт юм. Эдгээр параметруудийг тодорхойлохын тулд сургах өгөгдлүүдтэй хамгийн ойр дайрч гарах шулууныг тодорхойлно. Үүний тулд таамаглалын функц болон гаралтын утгын ялгавар хамгийн бага байх шаардлагатай юм (1).

$$h_{\theta}(x^{(i)}) - y^{(i)} \quad (6)$$

Бид шугам регрессийн адил үнэлгээний функцийг логистик функцэд хэрэглэж болохгүй ба хэрэглэсэн тохиолдолд энэ нь олон тооны локал минимумийг үүсгэдэг. Өөрөөр хэлбэл энэ нь хотгор функц биш юм. Тухайн системийн үнэлгээний функц J -ийг (7) илэрхийллээр тодорхойлно.

$$J(\theta) = \frac{1}{m} \sum_i^m C(h_{\theta}(x^{(i)}), y^{(i)}) \quad (7)$$

Хэрэв $y = 1$ бол

$$C(h_{\theta}(x^{(i)}), y^{(i)}) = -\log_{10}(h_{\theta}(x))$$

Хэрэв $y = 0$ бол

$$C(h_{\theta}(x^{(i)}), y^{(i)}) = -\log_{10}(1 - h_{\theta}(x))$$

Цаашилбал, үнэлгээний функцийн хоёр нөхцөлт тохиолдлыг нэг тохиолдолд багтааж доорх байдлаар бичиж болно.

$$J(\theta) = -\frac{1}{m} \sum_{i=1}^m [y^{(i)} \log(h_{\theta}(x^{(i)})) + (1 - y^{(i)}) \log(1 - h_{\theta}(x^{(i)}))] \quad (8)$$

Дээрх $J(\theta)$ функцийн минимумийг тодорхойлсноор $\theta_0, \theta_1, \theta_2$ параметруудийг олно.

$$\min_{\theta_0, \theta_1, \theta_2} J(\theta_0, \theta_1, \theta_2)$$

2.2.3 Параметрийг тодорхойлох буюу градиентын бууралт

Үнэлгээний функцийн параметруудийн минимум утгыг тодорхойлох шаардлагатай болохыг дээр авч үзсэн. Үүний тулд градиент бууралтын алгоритмыг ашиглана.

Эхлээд, $\theta_0, \theta_1, \theta_2$ параметруудийг дурын байдлаар сонгож авдаг хэдий ч, ихэнх тохиолдолд $\theta_0 = 0, \theta_1 = 0, \theta_2 = 0$ байхаар сонголтыг хийдэг байна. $J(\theta_0, \theta_1, \theta_2)$ функцийн утга багасах байдлаар параметруудийн утгыг өөрчилнө. Програмын алгоритм хэлбэрээр дүрсэлбэл,

Давхцал үүстэл давт()

$$\{\theta_j := \theta_j - \alpha \frac{\partial}{\partial \theta_j} J(\theta_0, \theta_1, \theta_2)\} \quad (5)$$

Энд, $j = 0, j = 1, j = 2$ байх ба α нь сурах хурд юм. α -н утга бага үед сурах хурд удаан байна. Харин α хэт их үед үсрэлтүүд үүссэний улмаас параметрийн минимум утгыг олох боломжгүй болдог.

Параметрийн минимум утгыг олохын тулд үнэлгээний функцээс хэсэгчилсэн уламжлалыг $\frac{\partial}{\partial \theta_j} J(\theta_0, \theta_1, \theta_2)$ авна.

2.2.4 Туршилтын үр дүн

Зураг 2.2.1-д үзүүлсэн хоёр сэнст дүүжин нь хэвтээ тэнхлэгтэй харьцангуй $\pm 20^\circ$ завсарт савлана. Бид сургалтын 110 өгөгдлийг цуглуулсан (Хүснэгт 2.2.1) ба контроллёр дээр тооцоолол хийх замаар параметруудийг тодорхойлов. Сурах хурдыг $\alpha=0.02$ байхаар сонгож 8 MHz давтамжид ажилладаг Atmega32 контроллёр дээр тооцооллыг гүйцэтгэсэн болно. Сургалтын үр дүнд дараах параметруудийг тооцоолов.

$$\theta_0 := -1,2483$$

$$\theta_1 := 0,0087$$

$$\theta_2 := -0,0067$$

Эндээс таамаглалын функц нь

$$h_\theta(x) = -1.2483 + 0.0087x_1 - 0.0067x_2$$

гэж гарна.

Таамаглалын функцийг $h_\theta(x) = 0.5$ гэж тооцон нэг сэнсний хурдны утгыг сонгон авснаар хоёр дахь сэнсний утгыг шийдвэрийн хилээс тооцоолно.

$$x_1 = \frac{0.5 + 1.2483 + 0.0067x_2}{0.0087}$$

Тооцоолсон шугаман хамаарлын үр дүнг Зураг 2.2.4-т ногоон шулуунаар дүрслэв. Туршилтаар бид эхний сэнсний хурдыг $x_2=830$ байхаар сонгон авахад хоёр дахь сэнсний хурдыг $x_1=788$ гэж тооцоолж гаргана. Хурдны нам утгад дүүжин тэнцвэрт орж чадахгүй байсан бөгөөд хурдыг $x_2=870$ байхаар сонгож авснаар систем $\psi=0$ өнцөгт хүрч чадаж байлаа.

2.2.5 Дүгнэлт

Хоёр сэнст тогтворгүй дүүжингийн системийг хяналттай сургалтын ангиллын аргаар сургаж туршилтыг амжилттай явуулав. Сурах хурд болох α -г туршилтаар тодорхойлсон бөгөөд $\alpha=0.02$ гэж тогтоов.

Энэхүү удирдлагын давуу тал нь тухайн системийн физик өгөгдлүүдийг тооцоолохгүйгээр, өөрөөр хэлбэл, системийн математик загварыг хэрэглэхгүйгээр зөвхөн сургалтын өгөгдөл дээр тулгуурлан дүүжинг тогтворжуулж байв.

Гэвч ангиллын аргын доорх сул талууд ажиглагдав. Сургалтын өгөгдлийн тоо ихсэхийн хэрээр тооцооллын хурд эрс буурч байсан ба үнэлгээний функцийн утгыг $J(\theta) = 0.03$ хүргэхийн тулд контроллёр дээрх тооцооллын давталт 3 цаг орчим үргэлжилж байлаа.

Сурах алгоритмыг суулгасан энэ систем нь тэжээлийн өөр өөр хүчдэлийн утгуудад, түүнчлэн өөр өөр жинтэй ачааны утгад дахин суралцах замаар дүүжинг өгөгдсөн өнцөгт тогтвортой барьж чадах нь харагдав.


2.3 Дөрвөн сэнстийн тэнцвэржилтийг машин сургалтын бататган сурах аргаар шийдэх нь

Сүүлийн үед тэгш хэмт бүтэцтэй дөрвөн сэнст нисгэгчгүй нисдэг тэрэгний хэрэглээний мужууд улам бүр нэмэгдсээр байна. Үүнийг даган түүнийг удирдах олон аргууд бий болсоор байна. Дөрвөн сэнстийн шугамчилсан динамик загварыг [21, 22, 23] үзүүлэв. Удирдлагын аргуудын тоонд сонгодог арга болох ПИД, илүү сайжруулсан аргууд болох төлөвийн гэдрэг холбоо болон LQR аргууд багтана [34, 35].

Системийн динамикийг математикаар бүрэн загварчлахад хүндрэлтэй, эсвэл шугамчилсан загвар нь системийн шугаман бус динамикийг өндөр нарийвчлалгүй загварт хүргэсэн тохиолдлыг авч үзье. Энэ тохиолдолд уламжлалт удирдлагын аргачлалыг ашиглан удирдахад бэрхшээлтэй тулгарна. Үүнийг машин сургалтын аргаар сайжруулах боломжтой юм. Энэхүү судалгаагаар бид дөрвөн сэнстийн нэг мөрийг машин сургалтын аргуудын нэг болох бататган сурах (RL-reinforcement learning) аргыг ашиглан тэнцвэржүүлэх удирдлагыг машин сургалтаар сургах зорилт тавьж туршин хэрэгжүүлж үзлээ. Энд бид дөрвөн сэнстийн удирдлагын асуудлыг Марковын шийдвэрийн процесс болгон тодорхойлж байна.

2.3.1 Бататган сургах арга

Бататган сургалт (RL) гэдэг нь тухайн орчинд агент ямар нэг үйлдэл хийх замаар хуримтлуулсан шагналыг нэмэгдүүлэх замаар суралцдаг машин сургалтын нэгэн чиглэл бөгөөд хяналттай сургалтын аргаас түүний ялгарах зүйл нь сургалтын оролт-гаралтын хосыг өгөх шаардлагагүй, агент өөрөө үйлдэл хийх замаар туршлагаасаа суралцахад оршино [6]. Энэхүү арга нь роботын удирдлагад илүү тохиромжтой байдаг [1, 13, 14, 15, 16, 40-44]. Бататган сурах аргын бүтцийг Зураг 2.3.1-д үзүүлэв.



Зураг 2.3.1. Бататган сурах аргын бүтэц

Энд, олон тооны S төлөвүүд нь орчин төлөөлөх ба агент буюу робот нь тогтсон үйлдлүүд болох A -с нэгийг сонгон харгалзах үйлдлийг хугацааны дискрет алхмуудад хуваан гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл, хугацааны t алхам тутамд агент орчны төлөв s_t -ийг ажиглаж эндээс хийх ёстой үйлдэл a_t -ийг сонгоно. Үйлдэл хийсний дараа агент нь r_{t+1} шагналыг хүртэх бөгөөд энэ нь богино хугацаанд хэр сайн үйлдэл хийснийг илтгэх ба агент нь орчны шинэ s_{t+1} төлөвийг ажиглана. Бататган сургалтын гол зорилго нь эдгээр дарааллаас $(s_t, a_t, r_{t+1}, s_{t+1})$ хуримтлагдах туршлагыг авч үзэх ба нэг төлөвөөс нөгөөд шилжих үнэ цэнийг сурч, үүнийгээ оновчтой утгын функц гэж тодорхойлдог [1, 4, 5].

Энэхүү судалгаанд бид бататган сургах аргын Q-сургалтын алгоритмыг ашигласан болно. Q-сургалтын оновчтой утгын функцийг дараах байдлаар тодорхойлно (1).

$$Q^*(s, a) = E[R(s, a) + \gamma \max_{a'} Q^*(s', a')] \quad (1)$$

Энэ нь s төлөвт a үйлдлийг гүйцэтгэснээр s' төлөвт шилжих үеийн хүлээгдэж буй үнэ цэнийг илэрхийлнэ. Параметр γ -г бууруулах фактор ($0 < \gamma < 1$) гэх бөгөөд ирээдүйд авах шагналын хэмжээнд хэр их ач холбогдол өгөхийг тодорхойлно. Нэгэнт оновчтой Q функцийг $Q^*(s, a)$ тодорхойлсон бол хамгийн оновчтой бодлого $\pi^*(s)$ -г тооцоолоход хялбар бөгөөд үүнд тухайн төлөвөөс хийгдэх бүх үйлдлүүдийн хамгийн их утгатайг сонгох юм (2).

$$\pi^*(s) = \arg \max_a Q(s, a) \quad (2)$$

Q-функцийг ихэвчлэн хүснэгтэд хадгалах бөгөөд төлөв s , үйлдэл a -р индексжүүлдэг. Дурын төлөвөөс эхлэн орчинг давтан ажиглах замаар бид оновчтой Q функцийг тодорхойлж болно. Робот үйлдэл хийх бүрд туршлагын дараалал $(s_t, a_t, r_{t+1}, s_{t+1})$ бий болдог. Төлөв s болон үйлдэл a -ийн хүснэгтийн нүдийг дараах байдлаар шинэчилнэ (3).

$$Q(s_t, a_t) = Q(s_t, a_t) + \alpha(r_{t+1} + \gamma \max_{a'} Q^*(s', a') - Q(s_t, a_t)) \quad (3)$$

Энэ нь эцэстээ оновчтой Q функц руу хувиран дөхнө.


Энэхүү сургалтын аргыг зарим тохиолдолд шагналын $R(s,a)$ функцэд суурилсан удирдлагын арга ч гэж тодорхойлдог [37, 38, 39]. Доод төвшний удирдлагын тооцооллыг боловсруулахын оронд бид шагналын функц хэлбэрээр илүү дээд төвшний даалгаврыг боловсруулан хэрэгжүүлж болно. Ихэнх тохиолдолд роботын даалгавар болон шагнал нь орчны физик үйл ажиллагаатай тохирдог. Түүнчлэн, шагналын функцийг сийрэг болон шигүү байдлаар тодорхойлох боломжтой юм. Урамшууллын сийрэг функц нь цөөн хэдэн газрыг эс тооцвол хаа сайгүй тэг утгатай байдаг бол шигүү шагналын функцийн хувьд үйлдэл бүрийн дараа илүү их мэдээлэл өгөх боловч уг функцийг бүтээх нь сийрэг функцээс илүү хүнд байдаг [22].

Q сургалтын арга нь дискрет төлөв болон харгалзах үйлдлүүдийг шаардана. Энэ тохиолдолд завсрын нууц төлөвүүдийг илрүүлэх боломжгүй буюу хангалттай зөв суралцах боломжгүй болдог. Зарим судалгаанд дээрх төлөв болон үйлдлүүдийг үргэлжилсэн байхаар шийдсэн байна [26].

Q-сургалтын хувьд орчны талаарх мэдээллийг нээн олж авах цорын ганц арга зам нь ямар нэг үйлдэл хийснээр орчны зүгээс өгөх хариу үр нөлөөг ажиглах явдал юм [18, 19, 20, 21, 22]. Сургалтын эхэнд хүрээлэн буй орчны талаар системд ямар нэгэн тодорхой мэдээлэл огт байхгүй байх тул санамсаргүй байдлаар, аль эсвэл хүчээр ямар нэгэн үйлдэл хийхийг систем шаардана. Үйлдэл бүрийн дараа шагнал хэлбэрийн мэдээлэл цугларах бүрд Q-сургалт нь утгын функцийг ойролцоолон сайжруулж байдаг.

2.3.2 Системийн загварт бататган сургах аргыг нэвтрүүлэх нь

Судалгааны системийн загварыг Зураг 2.3.2-т үзүүлэв. Бид энэхүү системийг 0 градус (хэвтээ тэнхлэгтэй давхцах байрлал) дээр тэнцвэрээ олж сурах зорилгоор бүтээсэн болно. Энэхүү системийн сургалтын программ хангамжийг Atmel SAM3X8E ARM 32-битийн микроконтроллер дээр хэрэгжүүлсэн болно. Өнцгийн мэдрүүрийг потенциометр ашиглан шийдсэн. Мөрний захад 2000KV эргэлт бүхий 30 Амперын ESC удирдлагатай сэнст хоёр хөдөлгүүр байрлана.



Зураг 2.3.2 Хоёр сэнст тэнцвэргүй систем

Бидний судалгаандаа дөрвөн сэнстийн нэг тэнхлэгийг судалгааны загвар болгосон тул энэ системийн S төлөвүүдийн олонлог нь өнцөг ψ , мөн өнцөг хурд ψ' -аар тодорхойлогдоно. Системийн хувьд мөр нь $\pm 20^\circ$ завсарт савлах ба өнцөг хурд нь $\pm 4^\circ/\text{sec}$ завсарт хувьсан өөрчлөгдөнө. Өнцөг нь нэг градусын дискрет алхамтай, өнцөг хурдыг 9 төвшинд дискретчилсэн болно. Ингэснээр манай системийн Q төлөв нь 41×9 хэмжээтэй болох ба Хүснэгт 2.3.1-д дараах байдлаар харуулав.

Хүснэгт 2.3.1. Q сургалтын дискрет төлөвийн хүснэгт

Өнц/ өнцөг хурд	-20	-18	-17	...	0	1	...	19	20
-4									
...									
0									
..									
4									

Үйлдэл A -г системийн төлөв бүрд харгалзах үйлдлүүдийн олонлог гэж тодорхойлсон ба энэ нь сэнсний эргэлтийн хурдыг өөрчлөх PWM дохио юм. Нийт 9 дискрет үйлдлийг системийн төлөвүүдэд өөрчлөлт оруулж чадахуйц байхаар сонгож авсныг Хүснэгт 2.3.2-т үзүүлэв.

Хүснэгт 2.3.2. Дискрет үйлдлүүд

Үйлдэл	a_1	a_2	a_3	a_4	a_5	a_6	a_7	a_8	a_9
PWM1	800	825	850	875	900	900	900	900	900
PWM2	900	900	900	900	900	875	850	825	800

Дөрвөн сэнстэд ESC удирдлага бүхий зүрхэвчгүй тогтмол гүйдлийн мотор (BLDC) ашигладаг бөгөөд энэхүү төхөөрөмж нь хөдөлгүүрийн хурдыг 20 мс тутамд өөрчлөх чадвартай юм. ESC-д PWM дохиог өгөх замаар хөдөлгүүрийн хурдыг удирдах боломжтой болно. PWM дохионы минимум утга нь 770 микросекунд байх ба максимум утга нь 2000 микросекунд байна. Өөрөөр хэлбэл бид хөдөлгүүрийн хурдыг 1 микросекундийн нарийвчлалтай өөрчлөх боломжтой юм. Үүнээс харахад бидэнд үйлдэл A-ийн хувьд өргөн сонголт байна. Өөрөөр хэлбэл, төлөв s_t бүрд нэг хөдөлгүүрийн хувьд 1230 үйлдлийг сонгох боломжтой хэдий ч энэ тохиолдолд манай Q хүснэгт асар том хэмжээтэй болсноор сургалтын процесс төвөгтэй болох юм. Сонгосон үйлдлүүдээс хамааран нэг төлөвөөс нөгөөд шилжих хугацаа өөрчлөгдөнө. Өөрөөр хэлбэл, ямар нэгэн үйлдлийг гүйцэтгэснээс хойш хэсэг хугацааны дараа шинэ төлөвийг ажиглах шаардлагатай бөгөөд энэ хугацааг бид 20 миллисекунд байхаар сонгож авав.

Бид бууруулах факторын $\gamma = 0.7$, сургалтын хурд болох $\alpha = 0.1$ байхаар тус тус сонгон авсан.

Программын алгоритмыг авч үзвэл:

1. Q хүснэгтийг анхны 0 утгаар дүүргэж ачаалах

while (1)

2. Санамсаргүй үйлдэл сонгох t тоолуурын утгыг ачаалах
3. **for** ($t > 1$) бол s_t төлөвөөс санамсаргүй үйлдэл сонгох эсвэл $a_t = \max_a Q(s, a)$ сонгож гүйцэтгэх
4. **Хүлээх 20 мс**
5. Шинэ төлөвийг s_{t+1} ажиглаж бүртгэж авах, шагналын функцийг $R(s, a)$ тооцоолох
6. Q хүснэгтийг шинэчлэх $Q(s_t, a_t) = Q(s_t, a_t) + \alpha(r_{t+1} + \gamma \max_a Q^*(s', a') - Q(s_t, a_t))$

Манай системийн Q матриц нь [9x41x9] хэмжээтэй ба үүнд 9 төрлийн өнцөг хурд ψ' , 41 төрлийн өнцөг ψ , мөн 9 төрлийн A үйлдлүүд багтана. Уг матрицын нүд бүрд 32-битийн float төрлийн утга хадгалагдах ба эндээс дүгнэхэд бидэнд хамгийн багадаа 13 Кбайт хэмжээний санах ой шаардлагатай. Төлөвийн тоо ихсэх, үйлдлийн тоо ихсэх бүрд санах ойн хэмжээ томорно.

Энэхүү сургалтын аргыг шагналд суурилсан сургалтын арга гэх ба шагналын функцийг оновчтой тодорхойлсноор сурах процесс зөв явагдана. Бидний туршилтаар хэд хэдэн төрлийн шагналын функцүүдийг авч үзсэн болно.

2.3.3 Туршилт ба үр дүн

Туршилт 1

Энэ туршилтаар сийрэг шагналын функцийг хэрэгжүүлэн туршилтыг хийсэн болно.

$if (\psi == 0 \ \&\& \ \psi' == 0)$

$Reward = 1;$

$else$

$Reward = 0;$

Энэ тохиолдолд нэг төлөв дээр систем үйлдэл бүрийг хийж гүйцэтгэсэн боловч шагналын утга өөрчлөгдөхгүй улмаас систем эхний төлөвөөс гарч чадахгүй байв. Өөрөөр хэлбэл бид нэг зорилгын төлөвтэй ба энэ төлөвөөс бусад төлөвүүд шагнал хүртэхгүй болно.

Туршилт 2

Энэ туршилтаар шигүү шагналын функцийг хэрэгжүүлэн туршилтыг хийсэн болно.

$Reward = abs(\psi) * (-1);$

Энэ тохиолдолд систем -20 градус болон +20 градусын үед хамгийн өндөр сөрөг шагналыг (шийтгэл) хүртэх ба 0 градус дээр 0 шагналыг хүртэнэ. Энэхүү туршилтын үед систем нэг төлөв дээр гацахгүй боловч тэнцвэрийг хадгалж чадахгүй хоёр тийш тасралтгүй савчиж байв.

Туршилт 3

$Reward = (\psi) + \psi';$

Энэхүү шагналын системийн хувьд хэдийгээр өнцөг хурдыг оруулж өгсөн боловч $\psi = -1$ болон $\psi = 1$ төлөв дээр тэнцвэрийг олохын тулд өнцөг хурдыг өндөр байх үйлдлийг сонгож байгаа нь харагдсан ба $\psi = 0$ төлөвийг өндөр хурдаар дайран өнгөрч байгаа нь харагдлаа.

Туршилт 4

$Reward = 1 - abs((\psi) + \psi');$

$if (abs(\psi) == 20)$

$Reward = -100;$

$if (abs(\psi) <= 3)$

$Reward = 100$


Энэхүү шагналын системийн хувьд бид шийтгэлийн утгыг оруулж өгсөн ба хэрэв савлуурын өнцгийн хэмжээ их, өнцөг хурдны хэмжээ бага бол сөрөг шагналыг их авна. Өнцгийн хэмжээ их, харин өнцөг хурд их тохиолдолд сөрөг шагналыг бага авна. Хэрэв өнцгийн хэмжээ бага, харин өнцөг хурд их бол сөрөг шагналыг ихийг

авах ба өнцгийн хэмжээ бага өнцөг хурд бага байвал сөрөг шагналыг бага авахаар шийдсэн болно.

Туршилт 5

$$Reward = 1 - (\psi + \psi')^2 - abs(\psi')$$

Энэхүү туршилтаар бид тавьсан зорилгодоо хүрч чадсан болно.



Зураг 2.3.3 Шагналын функц

Үүнээс гадна, үйлдэл хийсний дараа тодорхой хугацаагаар саатал авах шаардлагатайг туршилтаас тодорхойлсон болно. s_t төлөв дээрээс бид хамгийн өндөр утгатай үйлдэл a_t –г сонгон авч гүйцэтгэнэ. Үүний дараа бид шинэ төлөвийг s_{t+1} уншиж авна. Хэрэв үйлдлийг гүйцэтгэж дуусах хангалттай хугацаа өнгөрөөгүй тохиолдолд төлөв өөрчлөгдөх боломжгүй бөгөөд энэ төлөв дээр маш олон үйлдлийг хийж гүйцэтгэснээр Q хүснэгт худал утгаар шинэчлэгдэнэ. ESC төхөөрөмж 50 Hz давтамжтай ажиллаж байгаа тул бид 20мс саатал авсан болно.

Хүснэгт 2.3.3а-д эхний 60000 давталтын дараах Q функцийг үр дүнг үзүүлсэн болно. Энэхүү хүснэгтийн мөр нь (1-р мөр -20 градус, 41-р мөр +20 градус) өнцгийн ψ төлөв, багана нь өнцөг хурдны утгыг үзүүлсэн болно. Улаан өнгөөр сөрөг шагналыг, ногоон өнгөөр эерэг шагналыг дүрсэлсэн болно. Хүснэгт 2.3.3б-д 1000000 давталтын дараах Q функцийг үр дүнг үзүүлэв.

Хүснэгт 2.3.3 Q функцийн утга


-0.28	-0.31	-0.58	-1.8	-6.42	0	0	0	0	-1.57	-1.87	-2.76	-5.92	-10.81	0	0	0	0
-0.1	-0.11	-0.21	-0.24	-3.4	0	0	0	0	-0.92	-0.87	-1.54	-3.16	-8.19	0	0	0	0
-0.1	-0.1	-0.1	-0.52	-2.16	-0.72	0	0	0	-0.72	-0.75	-1.06	-3.22	-6.55	-4.3	0	0	0
0	0	-0.1	-0.41	-1.89	-0.46	0	0	0	-0.32	-0.57	-0.91	-2.64	-5.99	-3.45	0	0	0
0	-0.1	-0.11	-0.34	-1.62	-0.36	-0.2	0	0	-0.49	-0.66	-1.21	-2.66	-5.21	-2.95	-1.57	0	0
-0.1	0	-0.21	-0.27	-1.41	-0.49	-0.24	0	0	-0.32	-0.5	-1.19	-2.18	-4.19	-2.35	-1.99	0	0
0	-0.1	-0.1	-0.46	-1.15	-0.31	-0.26	-0.25	0	-0.21	-0.57	-1.18	-2.26	-3.82	-1.84	-1.16	-1.05	0
0	0	-0.13	-0.33	-1.34	-0.27	-0.16	-0.21	0	-0.29	-0.46	-1.07	-2.06	-3.55	-2.14	-0.87	-0.84	0
0	-0.1	-0.1	-0.34	-1.45	-0.58	-0.16	0	-0.1	-0.23	-0.34	-1.03	-1.87	-3.48	-2.19	-0.83	-0.56	-0.5
-0.1	0	-0.23	-0.35	-1.56	-0.31	-0.2	0	0	-0.44	-0.24	-0.85	-1.76	-4.08	-2.17	-0.93	-0.38	-0.36
-0.1	-0.1	-0.19	-0.5	-1.79	-0.38	-0.1	0	-0.1	-0.38	-0.5	-0.73	-2.16	-3.93	-2.13	-0.9	-0.52	-0.42
-0.1	0	-0.13	-0.55	-1.64	-0.22	-0.11	-0.1	-0.1	-0.37	-0.37	-0.96	-1.8	-3.45	-1.63	-0.86	-0.64	-0.33
-0.1	-0.1	0	-0.34	-1.33	-0.5	-0.1	0	0	-0.56	-0.2	-0.6	-1.49	-2.96	-1.86	-0.75	-0.53	-0.41
-0.1	-0.1	0	-0.35	-1.47	-0.64	-0.23	-0.1	0	-0.38	-0.4	-0.55	-1.48	-2.86	-1.79	-0.91	-0.42	-0.52
-0.1	0	0	-0.16	-0.92	-0.29	-0.19	0	0	-0.35	-0.11	-0.41	-1.01	-2.08	-1.06	-0.65	-0.11	-0.39
-0.1	0	0	-0.1	-0.66	-0.29	-0.1	0	-0.1	-0.41	-0.16	-0.21	-0.58	-1.26	-0.9	-0.45	-0.22	-0.23
-0.1	0	0	-0.05	-0.29	-0.13	-0.1	0	0	-0.46	-0.22	-0.27	-0.48	-1.01	-0.72	-0.39	-0.24	-0.13
-0.1	0	0	-0.01	-0.15	-0.01	0	0	0	-0.41	-0.21	-0.17	-0.32	-0.61	-0.31	-0.26	-0.14	-0.14
-0.17	-0.1	0	-0.04	-0.11	-0.01	-0.01	0	0	-0.47	-0.31	-0.21	-0.24	-0.43	-0.33	-0.25	-0.13	-0.05
-0.1	0	-0.01	0	-0.12	-0.01	0	-0.1	0	-0.4	-0.23	-0.21	-0.25	-0.44	-0.18	-0.14	-0.17	-0.07
-0.01	0	-0.1	-0.01	-0.14	-0.01	0	0	0	-0.44	-0.25	-0.28	-0.27	-0.41	-0.26	-0.21	-0.12	-0.12
-0.19	-0.1	-0.1	-0.02	-0.14	-0.01	0	0	0	-0.61	-0.28	-0.43	-0.29	-0.51	-0.25	-0.2	-0.19	-0.22
-0.11	-0.01	-0.2	-0.04	-0.17	-0.04	0	0	0	-0.65	-0.27	-0.49	-0.46	-0.6	-0.34	-0.29	-0.11	-0.21
-0.14	-0.1	-0.13	-0.2	-0.31	-0.04	-0.03	0	0	-0.61	-0.37	-0.52	-0.72	-0.88	-0.46	-0.37	-0.2	-0.17
-0.38	-0.11	-0.23	-0.28	-0.42	-0.22	-0.1	0	0	-0.86	-0.55	-0.79	-1.04	-1.3	-0.66	-0.3	-0.31	-0.28
-0.36	-0.1	-0.12	-0.32	-0.64	-0.12	-0.13	0	-0.02	-0.98	-0.68	-0.78	-1.16	-1.67	-0.95	-0.6	-0.36	-0.3
-0.34	-0.21	-0.22	-0.52	-0.99	-0.36	-0.21	0	-0.1	-1.23	-0.86	-1.18	-1.76	-2.35	-1.52	-0.84	-0.44	-0.48
-0.25	-0.22	-0.21	-0.54	-1.2	-0.42	-0.21	-0.13	-0.1	-1.06	-0.99	-1.33	-1.82	-2.65	-1.52	-0.88	-0.58	-0.6
-0.27	-0.22	-0.29	-0.58	-1.3	-0.62	-0.36	-0.11	-0.11	-1.13	-0.97	-1.36	-2.15	-2.97	-1.79	-1.09	-0.6	-0.63
-0.38	-0.43	-0.47	-0.87	-1.78	-0.76	-0.33	-0.29	-0.22	-1.56	-1.22	-1.74	-2.52	-3.29	-2.3	-1.45	-0.96	-0.96
-0.36	-0.17	-0.53	-0.86	-1.86	-0.71	-0.33	-0.18	-0.17	-1.38	-1.3	-1.77	-2.43	-3.68	-2.08	-1.44	-0.83	-0.9
-0.23	-0.32	-0.33	-0.83	-2.02	-1.01	-0.4	-0.21	-0.12	-1.3	-1.38	-1.37	-2.57	-3.39	-2.63	-1.59	-1.05	-0.91
-0.3	-0.43	-0.5	-1.09	-1.91	-1.13	-0.42	-0.3	-0.3	-1.41	-1.61	-2	-3.07	-3.67	-2.71	-1.48	-1.01	-1.43
0	-0.52	-0.43	-0.88	-2.13	-0.76	-0.52	-0.11	-0.11	0	-2.15	-1.71	-2.83	-3.92	-2.55	-1.66	-1.18	-0.91
0	-0.51	-0.63	-1.47	-2.4	-1.3	-0.54	-0.32	-0.3	0	-2.02	-2.18	-3.63	-4.41	-3.16	-1.99	-1.26	-1.14
0	0	-1.23	-1.35	-2.44	-1.02	-0.49	-0.26	-0.3	0	0	-3.42	-3.45	-4.52	-3.13	-1.83	-1.28	-1.42
0	0	-1.01	-0.99	-2.38	-1.21	-0.52	-0.33	-0.12	0	0	-3.34	-3.25	-4.69	-3.32	-1.81	-1.39	-1.38
0	0	0	-2.07	-2.21	-1.36	-0.68	-0.36	-0.57	0	0	0	-4.45	-4.61	-3.54	-2.67	-1.36	-1.87
0	0	0	-2.06	-2.48	-0.96	-0.69	-0.48	-0.68	0	0	0	-4.63	-4.87	-3.13	-2.15	-1.82	-1.87
0	0	0	-3.82	-1.62	-0.79	-0.55	-0.58	-0.58	0	0	0	0	-5.2	-4.07	-2.71	-2.05	-2.53
0	0	0	-4.32	-2.97	-1.79	-1.01	-1.61	-1.61	0	0	0	0	-5.83	-5.16	-3.98	-2.92	-3.65
-2.83	-2.68	-4.96	-9.05	-11.2	0	0	0	0	-7.73	-10.7	-15	-19.6	-20.88	0	0	0	0
-1.34	-1.73	-3.06	-6.2	-9.41	0	0	0	0	-5.57	-8.95	-12.9	-19.1	-20.38	0	0	0	0
-1.6	-1.11	-2.3	-6.14	-8.56	-6.79	0	0	0	-6.62	-8.94	-13	-18.4	-19.28	-19.2	0	0	0
-1.13	-1.49	-2.12	-5.49	-8.06	-5.84	0	0	0	-5.46	-8.23	-12.8	-17	-18.44	-18.2	0	0	0
-0.87	-1.27	-2.33	-4.21	-6.89	-5.74	-3.15	0	0	-6.56	-8.09	-12	-15.8	-17.64	-17.1	-14.1	0	0
-1.09	-1.28	-2.44	-3.92	-6.05	-4.71	-3.54	0	0	-5.81	-7.99	-11	-15.3	-16.06	-15.3	-13	0	0
-0.64	-1.13	-2.43	-3.85	-5.47	-3.45	-2.51	-1.92	0	-5.33	-6.75	-10.1	-14	-15.68	-14.8	-11.1	-9.95	0
-0.52	-1.05	-1.98	-3.66	-5.05	-3.83	-1.75	-1.95	0	-4.75	-5.9	-9.28	-13.9	-15.51	-13.8	-9.66	-9.32	0
-0.81	-0.55	-1.91	-3.27	-5.2	-3.84	-1.92	-1.32	-0.91	-4.75	-5.51	-8.76	-13.3	-15.33	-14	-10.4	-7.17	-5.23
-0.91	-0.68	-1.64	-3.14	-5.39	-3.57	-1.81	-0.87	-0.97	-4.36	-5.58	-7.32	-12.5	-14.37	-12.8	-9.67	-4.35	-3.32
-0.74	-1.06	-1.35	-3.38	-5.03	-3.57	-2.05	-0.97	-0.92	-4	-4.79	-7.32	-11.6	-13.95	-12.5	-8.8	-5.52	-3.96
-0.84	-0.73	-1.54	-3.27	-4.32	-3.01	-1.77	-1.13	-0.7	-3.73	-4.22	-6.62	-11.5	-12.71	-11.9	-8.07	-6.34	-3.64
-1.08	-0.6	-1.26	-2.85	-4.51	-3.09	-1.44	-0.81	-0.57	-3.62	-4.65	-6.55	-9.54	-11.13	-11	-8.02	-5.34	-3.59
-0.73	-0.85	-1.28	-2.47	-3.08	-3.1	-1.97	-1.01	-0.85	-4.15	-4.63	-6.29	-8.45	-9.39	-9.95	-7.2	-5.15	-4.61
-0.63	-0.32	-0.99	-1.8	-3.08	-2.25	-1.08	-0.5	-0.62	-3.72	-3.08	-4.63	-6.5	-8.19	-7.57	-5.82	-3.5	-3.11
-0.65	-0.32	-0.43	-1.06	-1.64	-1.78	-0.91	-0.41	-0.34	-4.02	-3.39	-4.02	-5.07	-6.63	-6.18	-5.03	-3.5	-3.12
-0.77	-0.47	-0.71	-0.87	-1.4	-1.22	-0.77	-0.42	-0.32	-4.39	-3.33	-3.89	-4.71	-5.31	-5.65	-4.49	-3.26	-3.09
-0.76	-0.36	-0.36	-0.55	-1.07	-0.71	-0.6	-0.31	-0.36	-4.33	-3.01	-3.43	-4.03	-4.65	-4.51	-3.84	-2.64	-2.3
-0.85	-0.48	-0.51	-0.62	-0.89	-0.63	-0.49	-0.27	-0.25	-5.17	-3.58	-3.58	-3.92	-3.95	-4.12	-3.53	-2.67	-2.45
-0.88	-0.5	-0.45	-0.55	-0.76	-0.45	-0.33	-0.26	-0.26	-5.03	-3.41	-3.57	-3.79	-4.04	-3.81	-3.09	-2.14	-2.11
-0.83	-0.52	-0.48	-0.56	-0.83	-0.58	-0.41	-0.28	-0.31	-5.46	-4.34	-4.04	-4.17	-4.25	-3.95	-3.33	-2.15	-2.18
-0.99	-0.64	-0.7	-0.65	-0.84	-0.61	-0.45	-0.28	-0.48	-6.81	-4.94	-4.72	-4.87	-4.49	-4.13	-3.42	-2.81	-2.48
-1.1	-0.56	-0.79	-0.9	-1.05	-0.58	-0.49	-0.28	-0.42	-6.76	-5.46	-5.43	-5.69	-5.44	-4.57	-3.68	-2.79	-3.12
-1.11	-0.91	-0.93	-1.18	-1.12	-0.99	-0.65	-0.42	-0.36	-8.18	-5.99	-6.15	-6.64	-6.95	-5.47	-4.21	-3.81	-3.53
-1.49	-1.07	-1.38	-1.56	-1.8	-1.25	-0.73	-0.65	-0.62	-9.25	-7.46	-7.99	-7.8	-7.78	-6.79	-5.04	-4.38	-4.33
-1.68	-1.13	-1.41	-2.1	-2.2	-1.47	-0.87	-0.65	-0.57	-9.97	-8.6	-8.53	-8.92	-9.23	-7.25	-6.05	-4.86	-4.25
-2.11	-1.83	-2.1	-2.73	-3.09	-2.24	-1.43	-0.78	-1.05	-11.5	-9.61	-10.1	-10.1	-10.37	-9.08	-7.29	-5.82	-5.6
-2.28	-1.55	-2.28	-3.09	-3.47	-2.54	-1.5	-1.02	-1.38	-12.1	-10.2	-11.2	-11	-11.5	-9.45	-7.94	-6.91	-7.1
-2.29	-1.69	-2.33	-3.24	-4.17	-2.84	-2.01	-1.18	-1.15	-12.9	-11.1	-12	-12.1	-12.98	-10.9	-8.73	-7.58	-7.34
-2.56	-2.32	-2.86	-4.04	-4.76	-3.4	-2.22	-1.45	-1.72	-13.8	-12.6	-12.9	-13.6	-13.19	-12.3	-10.7	-8.64	-8.77
-2.37	-2.49	-2.92	-3.93	-4.52	-3.47	-2.51	-1.76	-1.5	-14.2	-13	-13.6	-14.3	-13.58	-13.2	-11	-9.36	-8.69
-2.45	-2.44	-2.64	-4.28	-5.16	-4.15	-2.69	-1.79	-1.76	-14.3	-13.8	-14.2	-14.5	-15.25	-13.6	-11.8	-10.5	-9.11
-2.69	-3.1	-3.5	-4.57	-4.8	-4.32	-2.83	-2.13	-2.34	-14.4	-14.9	-15.2	-15.6	-14.93	-14.9	-12.8	-11.8	-10.8
0	-3.65	-3.36	-4.74	-5.63	-4.35	-2.84	-1.9	-1.75	0	-15.9	-15.7	-16.3	-16.3	-14.7	-13.2	-11.9	-10.6
0	-4.12	-3.95	-5.47	-5.82	-4.96	-3.58	-2.08	-2.38	0	-16.1	-16.2	-17	-17.12	-15.2	-14.8	-12.9	-11.6
0	0	-5.2	-5.18	-6.22	-4.72	-3.06	-2.42	-2.37	0	0	-17	-17.1	-16.56	-16.4	-14.9	-13.5	-12.6
0	0	-5.15	-5.19	-6.11	-5.47	-3.57	-2.8	-2.49	0	0	-17.4	-17.4	-17.9	-17.1</			

Хүснэгт 2.3.4-т төлөв бүрд харгалзах үйлдлүүдийн утгыг үзүүлэв. Энэхүү системийн сурах хугацаа хамгийн багадаа 8 цаг байна. Анхны тохиолдолд Q хүснэгтийн нүд бүр 0 утгаар дүүрсэн байх ба энд зөв үйлдлийн утгыг олохын тулд хүснэгт бүрийн нүдний утгыг сайжруулан шинэчлэх шаардлагатай байдаг. Зарим судалгааны ажлаас харахад сурах хугацааг багасгах аргууд байна [21, 22]. Тухайлбал, эхлээд гар удирдлагын аргаар тэнцвэржүүлэх үйлдлийг хийх замаар Q хүснэгтийн нүд бүрийг ойролцоо зөв үйлдлийн утгаар дүүргэсний эцэст сайжруулан сургах процессыг идэвхжүүлснээр сурах хурдыг ихэсгэж байна.

Хүснэгт 4. Төлөв дээрх үйлдэл

Өнөөг	хур1	хур2	хур3	хур4	хур5	хур6	хур7	хур8	хур9
-20	8	8	5	6	8	9	2	9	7
-19	6	1	2	7	8	5	2	6	6
-18	3	8	8	2	8	5	1	6	6
-17	3	2	1	4	5	6	3	1	1
-16	7	7	6	7	5	5	7	3	1
-15	7	7	3	6	5	8	6	2	6
-14	3	4	6	2	5	6	4	1	9
-13	4	4	5	3	8	5	3	1	6
-12	5	4	7	5	6	3	1	3	1
-11	4	4	4	8	7	4	7	4	1
-10	8	2	5	3	9	4	2	4	2
-9	1	2	3	1	4	3	4	1	3
-8	3	1	2	9	3	7	5	2	1
-7	6	6	8	3	4	7	1	8	2
-6	6	6	6	8	2	6	7	1	5
-5	5	6	6	4	6	1	2	1	3
-4	6	6	6	5	7	3	9	8	3
-3	4	9	4	1	7	2	5	4	1
-2	4	3	3	8	2	2	7	5	1
-1	4	9	3	3	6	5	3	7	6
0	3	4	4	7	3	8	5	9	6
1	8	9	5	6	7	3	6	3	7
2	2	8	7	3	3	1	4	3	4
3	5	2	6	7	8	7	1	3	3
4	1	6	5	1	6	8	2	2	4
5	1	4	5	9	4	3	7	3	1
6	3	3	7	3	6	4	6	2	3
7	7	2	1	6	9	1	5	5	2
8	9	2	9	4	9	3	5	8	5
9	9	6	2	7	8	7	3	8	5
10	2	3	9	3	6	1	3	4	7
11	3	8	8	6	7	9	6	4	4
12	4	4	9	3	4	2	6	4	4
13	4	8	3	7	2	5	2	2	4
14	7	6	1	5	1	3	5	2	8
15	2	4	8	5	6	6	1	9	2
16	4	7	4	2	2	1	8	1	1
17	3	6	6	9	3	7	6	8	6
18	8	2	6	6	2	5	4	7	1
19	6	7	4	7	1	2	5	3	5
20	1	2	1	1	2	4	3	7	1

Сургалтын үйл явцыг бид хянах үүднээс зорилгот төлөвт хүрч буй хугацааны диаграммыг Зураг 2.3.4-т үзүүлэв. Суралцах явц болон зорилгот төлөвт хүрэх тоо алхам алхмаар ихсэж байгааг доорх зургаас харж болно.



Зураг 2.3.4 Зорилгот төлөвт хүрч буй тоо

Зураг 2.3.5-т сургалтын бодит системийг үзүүлэв.



Зураг 2.3.5. Сургалтын бодит систем

2.3.4 Дүгнэлт

Энэхүү судалгаагаар хоёр сэнст савлуурын системийг бататган сурах аргаар сургасан үр дүнг танилцууллаа. Системийн динамикийн математик загваргүй ч Q-сургалтаар тэнцвэрийг хангаж чадах удирдлагыг үүсгэх боломжтой байгаа нь харагдав.

Сургах ажиллагааг микроконтроллёрт суурилсан удирдлагаар хэрэгжүүлсэн бөгөөд энд их багтаамжтай санах ойн шаардлагатай байна.

Төлөвийн болон үйлдлийн утгуудыг бид дискретчилсний улмаас нуугдмал төлөв болон үйлдлийг тодорхойлоогүй болно. Дискрет үйлдэл сонгосон тохиолдолд үйлдэл гүйцэтгэж дуусах (саатал) хугацааг зөв сонгох шаардлага гарч байна.

Сийрэг болон шигүү шагналын функцийг ашиглан сургалтыг хийсэн ба шагналын функцийг маш зөв зохион байгуулах шаардлагатай байна. Шагналын функцээс хамааран сургалтын үр дүн өөр гарч байна.

Энэхүү аргын сул тал нь суралцах хугацаа урт байна. Цаашид бид сурах хугацааг багасгах (boost) аргыг туршихаар ажиллаж байна.

2.4 Нейрон Сүлжээнд Суурилсан Дөрвөн Сэнстийн Удирдлага

Энэхүү судалгаагаар нейрон сүлжээнд суурилсан удирдлагын арга ашиглан дөрвөн сэнстийг тогтворжуулсан үр дүнгээс танилцуулж байна. Нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн динамикийг сурахын тулд нэг далд давхаргатай нейрон сүлжээний загварыг ашиглан тооцоолсон болно. Стандарт PID удирдлага ашиглан нейрон сүлжээний сургалтын өгөгдлийг цуглуулсан. Нейрон сүлжээний нислэгийн тогтворжилтыг шалгахдаа PID удирдлагаар цуглуулсан өгөгдлийг ашигласан. Нейрон сүлжээгээр сургасан үр дүн болон PID удирдлагын аргуудын туршилтын үр дүнг хооронд нь харьцуулсан үр дүнг танилцуулав. Бидний судалгааны онцлог нь тэнцвэрээ олж сурдаг жижиг хэмжээний нейрон сүлжээг микроконтроллер дээр сургахад оршино.

Сүүлийн жилүүдэд дөрвөн сэнст нисдэг төхөөрөмжүүд (UAV, quadcopter) иргэний болон цэргийн салбарт өргөн хэрэглэгдэж байна [41, 42, 43]. Дөрвөн сэнст нисгэгчгүй нисэх онгоцыг аврах ажиллагаа, тандалт, зураглал хийх, цахилгаан дамжуулах шугамд үзлэг хийх, хот суурин газрын хөдөлгөөнийг хянах, тариалангийн хяналт, шүрших, хилийн эргүүл, сураггүй алга болсон хүмүүсийг хайх, бага оврын ачаа тээш хүргэх зэрэг олон төрлийн хэрэглээ байдаг [34, 35, 36, 37].


Ихэнх дөрвөн сэнстүүд нь сонгодог удирдлагын арга болох PID (пропорциональ, интеграл, дериватив) удирдлагын аргыг ашиглан жолоодогддог [1-10]. PID удирдлагын арга, түүний янз бүрийн систем дэх хэрэглээ нь маш их ном зохиолуудад сайн тайлбарлагдсан байдаг [1-10]. Дөрвөн сэнстийг удирддаг өөр олон аргууд байдаг, үүнд: Linear Quadratic Regulator (LQR), Sliding mode, Backstepping, Feedback linearization, Adaptive, Robust, Optimal, L1, H^∞ , Fuzzy logic гэх мэт. Дөрвөн сэнстийн удирдлагын алгоритмуудын харьцуулалтыг [11-15]-д судалгаанд хийсэн байна. Судалгаагаар илүү үр дүнтэй аргуудыг авч үзсэн бөгөөд үүнд хиймэл оюун ухааны алгоритм, нейрон сүлжээний удирдлага, бататган сурах аргууд байна. Сонгодог аргатай харьцуулахад нейрон сүлжээний гол давуу тал нь удирдлагын шугаман бус шинж чанар юм. Нейрон сүлжээг стандарт PID удирдлагын систем ашиглан сургасан байна [36, 37, 38, 39, 40-44].

Машин сургалтын нэг арга болох хяналттай сургалтын хувьд оролтын утга (дөрвөн сэнстийн өнцөг) болон гаралтын утга (сэнсний эргэлтийн хурд) зэргээс бүрдэх хос өгөгдлүүдийг ашиглан сурдаг байна. Сургалтын өгөгдөл дээр суралцсаны дараа систем нь ирээдүйн оролтын өгөгдөл дээр тулгуурлан гаралтын утгыг таамагладаг.

2.4.1 Дөрвөн сэнстийн математик загвар

Дөрвөн сэнст нь "CROSS төрлийн" нисдэг тохиргоотой (Зураг 2.4.1) бөгөөд эсрэг талын хоёр хос сэнс цагийн зүүний дагуу, нөгөө хос сэнс нь цагийн зүүний эсрэг эргэлдэж эргэлдэх хүчийг тэнцвэржүүлнэ [20, 21]. Хүссэн гаралтыг гарган авахын тулд импульсийн өргөний модуляц (PWM) ашиглан сэнсний өргөх хүч болон Roll, Pitch, Yaw өнцгүүдийг өөрчлөх замаар удирддаг. Зургаан чөлөөний зэрэг бүхий дөрвөн сэнстийг авч үзье. Дөрвөн сэнстийн хөдөлгөөнийг эргэлтийн дэд систем (Roll, Pitch, Yaw) өнцгүүд болон огторгуйд шилжих дэд систем (өндөр ба х ба у байрлал) гэсэн хоёр дэд системд хувааж болно [20-24].

Шаардлагатай хэмжилтийг авахын тулд дөрвөн сэнстэд тохирох инерцийн хэмжилтийн системээр (IMU) тоноглогдсон байх ёстой. Энэхүү IMU нь хурд болон Эйлериин өнцгийг тооцоолоход шаардагддаг хурдатгал болон өнцөг хурдны мэдээллийг өгдөг [6]. Дөрвөн сэнстийн төвд массын төвд байрладаг, Зураг 2.4.1-т үзүүлэв.



Зураг 2.4.1. Дөрвөн сэнстийн их бие тэнхлэг

Хөдөлгөөний эргэлтийн тэгшитгэлийг их биеийн тэнхлэгийн Ньютон-Эйлериин аргыг ашиглан дараах ерөнхий томъёоллоор гаргаж авдаг [23, 24].

$$J\dot{\omega} + \omega \times J\omega + M_g = M_b \quad (1)$$

Энд, J -дөрвөн сэнстийн диагональ инерцийн матриц, ω - биеийн өнцгийн хурд, M_g - роторын инерцээс үүссэн гироскопийн моментууд, M_b - дөрвөн сэнстэд үйлчлэх хүчнүүд. Дөрвөн сэнстэд үйлчлэх хүчнүүд:

$$M_b = \begin{bmatrix} lU_2 \\ lU_3 \\ lU_4 \end{bmatrix} = \begin{bmatrix} lK_f(\omega_1^2 - \omega_3^2) \\ lK_f(\omega_2^2 - \omega_4^2) \\ K_m(\omega_1^2 - \omega_2^2 + \omega_3^2 - \omega_4^2) \end{bmatrix} \quad (2)$$

Энд, K_f ба K_M –үүд нь аэродинамик хүч ба моментийн тогтмол, ω_i нь i -р роторын өнцөг хурд. Ротор бүр нь дээш чиглэсэн F_i хүчийг үүсгэж, харгалзах роторын i -ийн эргэлтийн чиглэлийн эсрэг чиглэлд M_i моментыг үүсгэдэг.

Хөдөлгөөний эргэлтийн тэгшитгэл (1)-ийг (2)-р тэгшитгэлд орлуулснаар дараах хамаарлыг гаргана.

$$\begin{bmatrix} I_{xx} & 0 & 0 \\ 0 & I_{yy} & 0 \\ 0 & 0 & I_{zz} \end{bmatrix} \begin{bmatrix} \ddot{\phi} \\ \ddot{\theta} \\ \ddot{\psi} \end{bmatrix} + \begin{bmatrix} \dot{\phi} \\ \dot{\theta} \\ \dot{\psi} \end{bmatrix} \times \begin{bmatrix} I_{xx} & 0 & 0 \\ 0 & I_{yy} & 0 \\ 0 & 0 & I_{zz} \end{bmatrix} \begin{bmatrix} \dot{\phi} \\ \dot{\theta} \\ \dot{\psi} \end{bmatrix} + \begin{bmatrix} \dot{\phi} \\ \dot{\theta} \\ \dot{\psi} \end{bmatrix} \times \begin{bmatrix} 0 \\ 0 \\ J_r \omega_r \end{bmatrix} = \begin{bmatrix} lU_2 \\ lU_3 \\ U_4 \end{bmatrix} \quad (3)$$

Сүүлчийн тэгшитгэлийг өнцгийн хурдатгал болгон дахин бичвэл

$$\ddot{\phi} = \frac{l}{I_{xx}} U_2 - \frac{J_r}{I_{xx}} \dot{\theta} \omega_r + \frac{I_{yy}}{I_{xx}} \dot{\psi} \dot{\theta} - \frac{I_{zz}}{I_{xx}} \dot{\theta} \dot{\psi} \quad (4)$$

$$\ddot{\theta} = \frac{l}{I_{yy}} U_3 - \frac{J_r}{I_{yy}} \dot{\phi} \omega_r + \frac{I_{zz}}{I_{yy}} \dot{\phi} \dot{\theta} - \frac{I_{xx}}{I_{yy}} \dot{\theta} \dot{\psi} \quad (5)$$

$$\ddot{\psi} = \frac{1}{I_{zz}} U_4 - \frac{I_{xx}}{I_{zz}} \dot{\theta} \dot{\phi} + \frac{I_{yy}}{I_{zz}} \dot{\phi} \dot{\theta} \quad (6)$$

Дөрвөн сэнстийн хөдөлгөөний шилжилтийн тэгшитгэл нь Ньютоны 2-р хууль дээр суурилдаг.

$$m\ddot{r} = \begin{bmatrix} 0 \\ 0 \\ mg \end{bmatrix} + RF_b \quad (7)$$

Үүнд: $r = [x \ y \ z]^T$ инерцийн тэнхлэгээс дөрвөн сэнст хүртэлх зай, r – зай, \dot{r} – хурд, \ddot{r} – хурдатгал, m – дөрвөн сэнстийн масс, g – дэлхийн татах хурдатгал, F_b – дөрвөн сэнстэд үйлчлэх гравитацийн бус хүч. Үүнийг хөдөлгөөний хөрвүүлэлтийн тэгшитгэлд (7) орлуулан томъёог өргөжүүлбэл бид дараах тэгшитгэлийг олж авна.

$$m \begin{bmatrix} \ddot{x} \\ \ddot{y} \\ \ddot{z} \end{bmatrix} = \begin{bmatrix} 0 \\ 0 \\ mg \end{bmatrix} + \begin{bmatrix} c\psi c\theta & c\psi s\theta s\phi & s\phi s\psi + c\phi c\psi s\theta \\ c\theta s\psi & c\theta c\psi + s\phi s\psi s\theta & c\phi s\psi s\theta - c\psi s\theta \\ -s\theta & c\theta s\phi & c\phi c\theta \end{bmatrix} \begin{bmatrix} 0 \\ 0 \\ -U_1 \end{bmatrix} \quad (8)$$

Хурдатгалын хувьд тэгшитгэлийг дахин бичвэл дараах хэлбэртэй болно. Үүнд: c - \cos , s - \sin товчилсон нэршил.

$$\ddot{x} = \frac{-U_1}{m} (\sin \phi \sin \psi + \cos \phi \cos \psi \sin \theta) \quad (9)$$

$$\ddot{y} = \frac{-U_1}{m} (\cos \phi \sin \psi \sin \theta - \cos \psi \sin \phi) \quad (10)$$

$$\ddot{z} = g - \frac{-U_1}{m} (\cos \phi \cos \theta) \quad (11)$$

Шилжилтийн дэд систем нь шилжилтийн төлөвийн хувьсагч болон эргэлтийн хувьсагчдаас бүрдэнэ. Цаашид бид дөрвөн сэнстийн чөлөөний зэрэгт дүрслэгдсэн x_1 -ээс x_{12} хүртэлх төлөвийн векторуудыг дараах төлөвийн орон зай хэлбэрээр тодорхойлно.

$$\begin{aligned}
X &= \begin{bmatrix} x_1 & x_2 & x_3 & x_4 & x_5 & x_6 & x_7 & x_8 & x_9 & x_{10} & x_{11} & x_{12} \end{bmatrix}^T \\
\dot{x}_1 &= \dot{\varphi} = x_2 \\
\dot{x}_2 &= \ddot{\varphi} = x_4 x_6 a_1 - x_4 \omega_r a_2 + b_1 U_2 \\
\dot{x}_3 &= \dot{\theta} = x_4 \\
\dot{x}_4 &= \ddot{\theta} = x_2 x_6 a_3 + x_2 \omega_r a_4 + b_2 U_3 \\
\dot{x}_5 &= \dot{\psi} = x_6 \\
\dot{x}_6 &= \ddot{\psi} = x_2 x_4 a_5 + b_3 U_4 \\
\dot{x}_7 &= \dot{z} = x_8 \\
\dot{x}_8 &= \ddot{z} = g - \frac{U_1}{m} (\cos x_1 \cos x_3) \\
\dot{x}_9 &= \dot{x} = x_{10} \\
\dot{x}_{10} &= \ddot{x} = \frac{-U_1}{m} (\sin x_1 \sin x_5 + \cos x_1 \sin x_3 \cos x_5) \\
\dot{x}_{11} &= \dot{y} = x_{12} \\
\dot{x}_{12} &= \ddot{y} = \frac{U_1}{m} (\sin x_1 \cos x_5 - \cos x_1 \sin x_3 \sin x_5)
\end{aligned} \tag{12}$$

PID удирдлага ашиглан дөрвөн сэнстийг тогтворжуулахын тулд бид IMU мэдрэгчээс цуглуулсан Roll, Pitch, Yaw өнцгүүдийн өгөгдлийг ашиглана. Үүнд: a1-a5 болон b1-15 нь инерцийн тэгшитгэлийг товчлон бичсэн.

2.4.2 ПИД удирдлагын систем

ПИД удирдлагын арга нь үйлдвэрлэлийн удирдлагын систем болон тасралтгүй өөрчлөгддөг удирдлага шаарддаг бусад олон төрлийн хэрэглээнд өргөн хэрэглэгддэг гэдрэг холбоо бүхий удирдлагын механизм юм [10-20]. PID удирдлага нь e(t) алдааны утгыг хүссэн утга (SP) болон хэмжсэн процессын хувьсагч (PV) хоорондын зөрүүг тасралтгүй тооцоолохдоо пропорциональ, интеграл, дериватив нөхцөл дээр үндэслэн залруулга хийдэг.

$$e(t) = SP - PV(t) \tag{13}$$

$$u(t) = K_p e(t) + K_i \int_0^T e(\tau) d\tau + K_d \frac{de(t)}{dt} \tag{14}$$

Дээрх тэгшитгэлд K_p , K_i , K_d – үүд бүгд эерэг байх бөгөөд пропорциональ, интеграл, дериватив нөхцөлийн коэффициентийг тэмдэглэдэг.

Roll өнцгийг засах томьёо:

$$R_{er,roll} = x_1 - S_{roll} \tag{15}$$

$R_{er,roll}$ - roll өнцгийн алдаа

x_1 - roll IMU-с хэмжсэн утга

S_{roll} – roll өнцгийн хүссэн утга

$$R_{err,roll} = K_{i,roll} * R_{er,roll} \tag{16}$$

$R_{err,roll}$ –roll өнцгийн хуримтлагдсан алдаа

$K_{i,roll}$ – roll өнцгийн интеграл коэффициент

$$U_{roll} = K_{p,roll} * R_{er,roll} + R_{err,roll} + K_{i,roll} * (R_{er,roll} + R_{d,err,roll}) \quad (17)$$

$R_{d,err,roll}$ – roll өмнөх алдаа

U_{roll} – roll өнцгийн зассан утга

Pitch өнцгийг засах томъёо:

$$R_{er,pitch} = x_3 - S_{pitch} \quad (18)$$

$R_{er,pitch}$ – pitch өнцгийн алдаа

x_3 – pitch IMU-с хэмжсэн утга

S_{pitch} – pitch өнцгийн хүссэн утга

$$R_{err,pitch} = K_{i,pitch} * R_{er,pitch} \quad (19)$$

$R_{err,pitch}$ – pitch өнцгийн хуримтлагдсан алдаа

$K_{i,pitch}$ – of pitch өнцгийн интеграл коэффициент

$$U_{pitch} = K_{p,pitch} * R_{er,pitch} + R_{err,pitch} + K_{i,pitch} * (R_{er,pitch} + R_{d,err,pitch}) \quad (20)$$

$R_{d,err,pitch}$ – pitch өнцгийн өмнөх алдаа

U_{pitch} – pitch өнцгийн зассан утга

Yaw өнцгийг засах томъёо:

$$R_{er,yaw} = x_5 - S_{yaw} \quad (21)$$

$R_{er,yaw}$ – yaw өнцгийн алдаа

x_5 – yaw IMU-с хэмжсэн утга

S_{yaw} – pitch өнцгийн хүссэн утга

$$R_{err,yaw} = K_{i,yaw} * R_{er,yaw} \quad (22)$$

$R_{err,yaw}$ – yaw өнцгийн хуримтлагдсан алдаа

$K_{i,yaw}$ – yaw өнцгийн интеграл коэффициент

$$U_{yaw} = K_{p,yaw} * R_{er,yaw} + R_{err,yaw} + K_{i,yaw} * (R_{er,yaw} + R_{d,err,yaw}) \quad (23)$$

$R_{d,err,yaw}$ – yaw өнцгийн өмнөх алдаа

U_{yaw} – өнцгийн зассан утга

Бидний ашигладаг электрон хурд хянагч /ESC/ нь 800-2000 PWM хооронд ажилладаг. Гэсэн хэдий ч бид PWM гаралтын утгыг дээд тал нь 1700, хамгийн багадаа 1300 хүртэл хязгаарласан. PWM-ийн тохируулагч утгыг $w_0=1500$ байхаар тохируулсан. Мотор бүрийн эргэлтийн хурдыг дараах томъёогоор тооцоолно.

$$w_1 = PWM_1 = \omega + U_{pitch} + U_{roll} - U_{yaw} \quad (24)$$

$$w_2 = PWM_2 = \omega + U_{pitch} - U_{roll} + U_{yaw} \quad (25)$$


$$w_3 = PWM_3 = \omega - U_{pitch} - U_{roll} - U_{yaw} \quad (26)$$

$$w_4 = PWM_4 = \omega - U_{pitch} + U_{roll} + U_{yaw} \quad (27)$$

2.4.3 Санал болгож буй нейрон сүлжээний загвар

Дөрвөн сэнстийн удирдлагад нейрон сүлжээг ашиглах сонголт нь параметрийн тооцоо болон агаарын нөлөөлөл зэргээс шалтгаалан их хэмжээний тодорхойгүй байдлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлагад үндэслэсэн болно [9]. Ийм динамикийг нейрон сүлжээг ашиглан загварчлах нь боломжит нэг арга юм. Нейрон сүлжээг (NN) универсал дөхөлтийн функц мэт ойлгож болно. Тэдний бүтэц шугаман бус функцүүдийг загварчлах болон ажиглагдаагүй төлөвүүдийг цуглуулсан өгөгдлөөс загварчлах боломжийг олгодог юм [10]. Түүгээр ч зогсохгүй цуглуулсан өгөгдлөөс ерөнхий загварт суралцах боломжтой. Гэсэн хэдий ч, санал болгож буй NN-д суурилсан загварыг системийг удирдахад ашиглаж болох эсэх, сурсан динамик нь сургалтад ашигласан өгөгдлөөс илүү системийг үнэн зөв илэрхийлж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Энэхүү судалгаагаар гурван давхаргатай NN загварыг санал болгож байгаа бөгөөд үүнд, оролтын давхарга, далд давхарга, гаралтын давхаргаас бүрдэнэ. NN-ийн архитектурыг Зураг 2.4.2-т үзүүлсэн бөгөөд үүнийг дараах байдлаар тайлбарлаж болно: оролтын давхарга нь системийн одоогийн төлөв болон оролт болгон авдаг. Сургалтын өмнө оролтын давхаргын жингийг санамсаргүй $\theta_{i,j}^{(1)}$ оноож, b_1 суурь утга нэмсэн. Хоёр дахь давхарга нь 10 нейронтой ба жинг санамсаргүй $\theta_{i,j}^{(2)}$ байдлаар сонгож нэмэлт суурь, b_2 -г нэмсэн. Сигмоид функцийг энд авч үзнэ. N далд нэгж тус бүр нь $\theta_{i,j}^{(1)}$ -ийн өмнөх үржвэрийг тооцоолдог. Гаралтын давхарга нь мотор бүрийн хурдыг илэрхийлдэг 4 нейронтой.



Зураг 2.4.2. Нейрон сүлжээний загвар

Загварын матриц дүрслэлийг доор үзүүлэв.

$$\begin{bmatrix} b^1 \\ x_1 \\ x_2 \\ x_3 \end{bmatrix} \rightarrow \begin{bmatrix} b^{(2)} \\ a_1^{(2)} \\ a_2^{(2)} \\ \cdot \\ \cdot \\ a_{10}^{(2)} \end{bmatrix} \rightarrow \begin{bmatrix} h_\theta(x)_1 \\ h_\theta(x)_2 \\ h_\theta(x)_3 \\ h_\theta(x)_4 \end{bmatrix}$$

Далд давхаргын нейроныг дараах тэгшитгэлээр (1-7) тооцоолж болно.

$$a_i^2 = g(\theta^T x) \quad (28)$$

$$z = \theta^T x = \theta_0 + \theta_1 x_1 + \theta_2 x_2 + \dots \quad (29)$$

$$a_i^2 = g(z) = \frac{1}{1+e^{-z}} = \frac{1}{1+e^{-\theta^T x}} \quad (30)$$

Сигмоид функц нь аливаа бодит тоог 0-ээс 1 интервалд хувиргадаг.

$$\begin{aligned} a_1^{(2)} &= g(\theta_{10}^{(1)} b^1 + \theta_{11}^{(1)} x_1 + \theta_{12}^{(1)} x_2 + \theta_{13}^{(1)} x_3) \\ a_2^{(2)} &= g(\theta_{20}^{(1)} b^1 + \theta_{21}^{(1)} x_1 + \theta_{22}^{(1)} x_2 + \theta_{23}^{(1)} x_3) \\ a_n^{(2)} &= g(\theta_{n0}^{(1)} b^1 + \theta_{n1}^{(1)} x_1 + \theta_{n2}^{(1)} x_2 + \theta_{n3}^{(1)} x_3) \end{aligned} \quad (31)$$

Энд, $n = [1:10]$

Дараах томъёогоор гаралтын нейронуудыг тооцоолдог:

$$\begin{aligned} h_\theta(x)_1 &= a_1^{(3)} = w_1 = g(\theta_{10}^{(2)} b^2 + \theta_{11}^{(2)} a_1^{(2)} + \theta_{12}^{(2)} a_2^{(2)} + \theta_{13}^{(2)} a_3^{(2)} + \dots + \theta_{110}^{(2)} a_{10}^{(2)}) \\ h_\theta(x)_2 &= a_2^{(3)} = w_2 = g(\theta_{20}^{(2)} b^2 + \theta_{21}^{(2)} a_1^{(2)} + \theta_{22}^{(2)} a_2^{(2)} + \theta_{23}^{(2)} a_3^{(2)} + \dots + \theta_{210}^{(2)} a_{10}^{(2)}) \\ h_\theta(x)_3 &= a_3^{(3)} = w_3 = g(\theta_{30}^{(2)} b^2 + \theta_{31}^{(2)} a_1^{(2)} + \theta_{32}^{(2)} a_2^{(2)} + \theta_{33}^{(2)} a_3^{(2)} + \dots + \theta_{310}^{(2)} a_{10}^{(2)}) \\ h_\theta(x)_4 &= a_4^{(3)} = w_4 = g(\theta_{40}^{(2)} b^2 + \theta_{41}^{(2)} a_1^{(2)} + \theta_{42}^{(2)} a_2^{(2)} + \theta_{43}^{(2)} a_3^{(2)} + \dots + \theta_{410}^{(2)} a_{10}^{(2)}) \end{aligned} \quad (32)$$

Энд:

x_n – оролтууд

$a_i^{(j)}$ - j давхаргын i идэвхжүүлэгч нэгж

$\theta_i^{(j)}$ - j давхаргаас $j + 1$ руу хөрвүүлэх i -р утга

Бидний зорилго бол давхарга бүрийн жингийн $\theta_{i,j}^{(l)}$ параметруудийг тодорхойлох явдал юм. Эдгээр параметруудийг зөв тодорхойлохын тулд таамаглах функц $h_\theta(x)_i$ болон гаралтын утгын y^i хоорондын зөрүүг хамгийн бага хэмжээнд байлгах шаардлагатай. Энд y^i нь нейрон сүлжээг сургахын тулд PID удирдлагаас цуглуулсан моторын эргэлтийн хурд юм.

$$loss = h_\theta(x^{(i)}) - y^i \quad (33)$$

Нейрон сүлжээний үнэлгээний функц $J(\theta)$ нь (34) тэгшитгэлээр тодорхойлогддог.

$$J(\theta) = -\frac{1}{m} \sum_{i=1}^m \sum_{k=1}^K \left[y_k^i \log \left(\left(h_\theta(x^{(i)}) \right)_k \right) + (1 - y_k^i) \log \left(1 - \left(h_\theta(x^{(i)}) \right)_k \right) \right] \quad (34)$$

Энд, k нь гаралтын нэгжийн тоо.

Үнэлгээний функц нь таамаглалын функцийн утга ба гаралтын утгын зөрүүг тодорхойлдог. Сургалтын үйл явцын гол санаа нь үнэлгээний функцийн $J(\theta)$ -ийн хамгийн бага утгыг тодорхойлох явдал юм. Хамгийн бага утгыг тодорхойлохын тулд бид үнэлгээний функцээс хэсэгчилсэн дифференциал авдаг. Энэхүү хэсэгчилсэн дифференциалыг тооцоолохын тулд бид "буцах тархалт" алгоритмыг ашигладаг. Эхлээд бид $y^{(t)}$ гаралтын утга ба таамагласан гаралтын утга $a^{(L)}$ хоорондын $\delta^{(L)}$ зөрүүг тооцоолно (35).

$$\delta^{(L)} = a^{(L)} - y^{(t)} \quad (35)$$

Дараа нь давхарга бүрийн ялгааг дараах томъёогоор тооцоолно (36).

$$\delta^{(L-1)}, \delta^{(L-2)}, \dots, \delta^{(2)}$$

$$\delta^{(l)} = ((\theta^{l+1})^T \delta^{(l+1)}) * a^{(l)} * (1 - a^{(l)}) \quad (36)$$

Үүний дараа хэсэгчилсэн дифференциалыг тооцоолно (37).

$$\frac{\partial}{\partial \theta_{i,j}^{(l)}} J(\theta) = a_j^{(l)} \delta_i^{(l+1)} \quad (37)$$

Жингийн $\theta_{i,j}^{(l)}$ параметруудийг дараах томъёогоор шинэчилнэ (38).

$$\theta_{i,j}^{(l)} := \theta_{i,j}^{(l)} - \alpha \frac{\partial}{\partial \theta_{i,j}^{(l)}} J(\theta) \quad (38)$$

Энд, α нь сургалтын хурд.

Үнэлгээний функц хамгийн бага утгад хүрэх хүртэл бид жингийн параметруудийг шинэчилсэн.

2.4.4 Туршилтын үр дүн

Сургалтад зориулж өгөгдөл цуглуулахын тулд бид PID удирдлагаар ажиллаж байгаа загвараас (x1-roll, x2-pitch, x3-yaw өнцөг) төлөвийг оролтын өгөгдөл болгон, дөрвөн сэнсний эргэлтийн хурдыг (w_1, w_2, w_3, w_4) гаралтын өгөгдөл болгон бүртгэж авсан. Туршилтын орчинг Зураг 2.4.3-т үзүүлэв. Бид нейрон сүлжээний загварыг боловсруулахын тулд 7000 өгөгдөл цуглуулсан. Нийт өгөгдөл гурван хэсэгт хуваагдана: 70% нь сургалт, 20% нь баталгаажуулалт, 10% нь тестлэхэд зориулагдсан.



Зураг 2.4.3. Дөрвөн сэнстийн сургалтын орчин


Нейрон сүлжээний загварыг MATLAB ашиглан сургасан. Сүлжээний зарим параметруудийг дараах байдлаар тохируулсан: суралцах хурд (0.001), зохицуулалтын хүчин зүйлгүй, давталт (9M), давхаргын тоо, далд давхарга дахь нейроны тоо. Нейрон сүлжээг сургахаасаа өмнө бид өгөгдлийг урьдчилан боловсруулах хэд хэдэн алхмуудыг дагаж мөрддөг.

Бид дроны байрлалыг оролт болгон аваагүй, харин дроны өнцгийг нейрон сүлжээнд оролт болгон өгсөн. Роторын эргэлтийн хурд буюу PWM утгыг 800-аас 2000 хүртэлх интервалаар өгсөн. Бид цуглуулсан гаралтыг (эргэлтийн хурд - PWM утга) масштабаар тооцсон бөгөөд тэдгээр нь тус бүр нь 0-ээс 1-ийн хооронд утгатай байна (39).

$$y_i = \left(\frac{w_i - 700}{2000} \right) \quad (39)$$


Энэ нь нейрон сүлжээ цуглуулсан өгөгдөл тэнцүү жин өгөх явдал юм.


Бид дронд зохиомлоор 15-20 градус хазайлган гадны нөлөө үзүүлж, онгоцонд үүссэн өнцгийг хэмжиж Зураг 2.4.4-т тэмдэглэв. Тус зурагт хэвтээ буюу X тэнхлэгийн дагуу сургалтын өгөгдөл, босоо тэнхлэгт өнцгүүдийг үзүүлэв.



Зураг 2.4.4. Гадны нөлөөгөөр үүссэн дроны өнцгийн өөрчлөлт


Дроны ажиллагаанд бид моторт өгөгдөж буй PWM утга болон дроны өнцгийн өөрчлөлтийг 1 секундэд 50 удаа бүртгэж авч сургалтын өгөгдлийн цуглуулсан болно. Үүний дараа supervised learning арга ашиглан жижиг Neural Network-ийн загвар үүсгэн сургасан болно. Зураг 2.4.5-аас зураг 2.4.8-д PID удирдлагаар тохируулсан моторын эргэлтийн хурдны өнцгийн өөрчлөлтөөс хамаарсан хамаарлыг цэнхэр өнгөөр, улбар шар өнгөөр нейрон сүлжээний загвараар сурсан моторын эргэлтийн хурдыг мотор тус бүрээр нь харуулсан болно. Зурагт босоо тэнхлэгийн дагуу моторын эргэлтийн хурд, хэвтээ тэнхлэгт сургалтын өгөгдлийг үзүүлэв. Моторын эргэлдэх хурдыг rotation per minute (rpm) -р тодорхойлно. Эргэлтийн хурдыг бид PWM буюу импульсийн өргөний модуляцаар удирдана.





Зураг 2.4.5. PID моторын эргэлтийн хурд, NN-ийн сурсан эргэлтийн хурд

Хоёр дахь туршилтаар бид далд давхарга дахь зангилааны тоог өөрчилсөн. Далд давхарга дахь зангилааны тооноос хамааран нисгэгчгүй онгоцны динамик загвар өөрчлөгдөнө. Үнэлгээний функцийн утгыг тодорхойлохын тулд бид зангилааг 3, 10, 20 болгож өөрчилсөн. Зураг 2.4.6-д зангилааны тооноос хамааран үнэлгээний функцийн утгын өөрчлөлтийг харуулав. Далд давхаргын тоог бүр ихэсгэвэл контроллёрын тооцоолол ихсэж 1 секундэд 50 удаа засвар хийх хугацаа уртсаж тэнцвэрээ олох нөхцөл муудаж магадгүй.



Зураг 2.4.6. Үнэлгээний функцийн утга ба зангилааны тооны хамаарал

Бид үргэлжлүүлэн далд давхаргын тоог нэмж хасаж сургалт явуулахаар төлөвлөж байна.

2.4.5 Дүгнэлт

Энэхүү судалгаад үзүүлсэн туршилтын үр дүн нь нейрон сүлжээний удирдлагыг дөрвөн сэнстийн нислэгийг тогтворжуулахад ашиглаж болохыг харуулсан. Нисдэг биетэд ийм хяналтыг ашиглах нь объектын тогтвортой байдлыг сайжруулах боломжийг олгоно. Учир нь нейрон сүлжээний удирдлага нь гадны нөлөөллийг оролтод өгөх үед удирдлагыг илүү сайн тогтворжуулдаг байна. PID удирдлагад өнцгийн тохируулга бүрд 3 коэффициент ашигладаг бөгөөд дөрвөн сэнстийг удирдахад нийт 9 коэффициент шаардлагатай. Далд давхаргад 3 нейронтой NN нь дөрвөн сэнстийн удирдахын тулд 28 коэффициент шаарддаг. Далд нейрон тоо нэмэгдэх хэрээр коэффициентын тоо нэмэгдэнэ. Өмнөх судалгаагаар бид PWM болон моторын эргэлтийн хоорондын хамаарлыг гаргасан болно. Судалгааны дараагийн шатанд бид нейрон сүлжээг судлан сайжруулж бататган суралцах /Reinforcement/ сургалтын загвартай хослуулсан туршилтуудыг хийх болно.

3. Төслөөс үүссэн бусад судалгааны ажлууд

Энэхүү судалгааны ажлын үндсэн дээр бид хиймэл оюун ухааны машин сургалтын арга дээр тулгуурласан хэд хэдэн судалгааны ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн болно.

3.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцрийн хөгжүүлэлт

Өнөөгийн байдлаар Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 105,730 байна. Монголд хэрэглэж буюу тэргэнцэр нь механик буюу хүн өөрийн гараар дугуйгаа эргүүлэх замаар удирдаг. Орчин үеийн технологи хөгжсөнөөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан төрөл бүрийн автомат системүүд бий болж байна. Үүний нэг жишээ нь: автомат тэргэнцэр юм. Цахилгаан хөдөлгүүр болон батарейн технологиуд жилээс жилд сайжирч байгаа тул хөдөлгүүрт суурилсан тэргэнцрүүд их болж байна. Тэргэнцрийн дизайны биомеханик талууд бие бялдрын хувьд чухал үүрэг гүйцэтгэдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйл ажиллагаа, нийгмийн оролцоонд маш чухал. Цахилгаан тэргэнцрүүдийг Joystick-н тусламжтайгаар түлхүү удирддаг байна. Зарим тохиолдолд Joystick ашиглана удирдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна. Орчин үеийн удирдлагын нэг арга болох машин

сургалтын аргууд энэхүү салбарт өргөн нэвтэрч эхлээд байна. Технологийн болон машин сургалтын арга ашиглан энэхүү асуудлыг шийдэх боломжтой юм. Энэхүү судалгаагаар гараар удирдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан хүний толгойн хөдөлгөөнийг сурах замаар нейрон сүлжээний арга дээр суурилан цахилгаан тэргэнцрийг удирдах аргын судалгааг танилцуулж байна. Үүний тулд эхлээд бид сүүлийн үеийн цахилгаан хөдөлгүүрүүдийн судалгаа, харьцуулалтуудыг хийсэн мөн хиймэл оюун ухааны нэг арга болох нейрон сүлжээний сургалтын аргыг судалсан болно. Хүний толгойн 5-н төрлийн хөдөлгөөний өгөгдлүүдийг цуглуулж цахилгаан тэргэнцрийн хөдөлгөөн болгох удирдлагын асуудлыг нейрон сүлжээний аргаар сургахаар зорилоо. Хүний толгойн хөдөлгөөнийг сурах замаар цахилгаан тэргэнцрийг удирдах боломжтойг энэхүү судалгаагаар бид харуулсан.

Цахилгаан тэргэнцрийг Зураг 3.1.1-т үзүүлэв.




Зураг 3.3.1. Бодит төхөөрөмж

Судалгааны ажлын хүрээнд түгээмэл хөгжил төв дээр очиж тэргэнцэр хэрэглэдэг хүмүүст ямар асуудал тулгардаг талаар ярилцсан. Тэргэнцрийн маш олон загварууд байдаг байна. Түүн дотроос хамгийн түгээмэл нь хойно том дугуйтай тэргэнцэр юм. Дэд бүтэц нь хөгжсөн газар ихэнх тохиолдолд сойзгүй мотор болон дугуй жижигтэй тэргэнцрүүд ашигладаг. Тогтмол гүйдлийн моторын давуу тал нь сул эргэлт үгүй тул налуу зам дээр хойш сул эргэх үзэгдэл байхгүй. Тэргэнцрийн моторт контакт тоормос ашигладаг ба сул зогсолтын үед гүйхээс хамгаалдаг. Цахилгаан тэргэнцрийн хөдөлгөөнийг Joystick гар ашиглан удирдаж байна. Тэргэнцрийн хөдөлгөөн нь урагш, хойш, зүүн, баруун эргэх үйлдлүүд багтаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоонд биеийн дөрвөн мөчний асуудалтай хүмүүс байдаг ба энэхүү хүмүүс өөр хүний тусламжтайгаар шилжилт хөдөлгөөн хийдэг байна. Бид толгойн хөдөлгөөнийг ашиглан цахилгаан тэргэнцрийг хэрхэн удирдаж болох

талаар судалгаа хийсэн. Толгойн хөдөлгөөнийг хурдатгал болон гироскоп мэдрүүрийн тусламжтайгаар мэдэрч байна.

Хүний толгойн хөдөлгөөнийг цахилгаан тэргэнцрийн хөдөлгөөн болгох функцийг тодорхойлохын тулд хүний толгойн хөдөлгөөний төрлүүдийг судлах шаардлага гарсан.




Зураг 3.1.2. Толгойн хөдөлгөөний төрөл

Хүний толгойн хөдөлгөөнийг 3 нөхцөлд авч үзсэн. Зураг 3.1.2a-д хүний толгой хүзүүн дээр төвлөрч хөдөлгөөн хийх боломжтойг харуулж байна. Зураг 3.1.2b-д хүний толгойн хөдөлгөөн цээжний хөдөлгөөнтэй хамт хийх боломжтой байна. Мөн Зураг 3.1.2c-д хүний толгойн хөдөлгөөн тэргэнцрийн хөдөлгөөнтэй хамт хийх боломжтой харж болно. Энэ бүх хөдөлгөөн шилжилтүүд толгой дээр байрлах мэдрүүрт өөр өөр утгуудыг өгөх ба эндээс бид тэргэнцрийн удирдлагын дохиог ялгах шаардлага тулгарна. Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс саажилтын улмаас толгой савлах үйлдлүүдийг хийдэг ба энэ дохиог бид удирдлагын дохионоос ялгах асуудлыг шийднэ.

Толгойн хөдөлгөөнийг удирдлагын дохио болгохын тулд бид машин сургалтын нэг арга болох нейрон сүлжээний аргыг хэрэглэсэн. Энэхүү аргыг хэрэглэхийн тулд бид толгойн хөдөлгөөнийг удирдлагын дохио болгох болон бусад хөдөлгөөнүүд гэж ангилж өгөгдлийг цуглуулсан. Цуглуулсан өгөгдлийг Матлаб программ ашиглан сургалтыг хэрэгжүүлсэн. Удирдлагын бүтцийн схемийг Зураг 3.1.3-т үзүүлэв. Матлаб программ дээр үүссэн машин сургалтын загварыг микроконтроллёрт суулгасан. Хүний толгойн хөдөлгөөнийг MPU6050 мэдрүүрийн тусламжтай мэдэрч микроконтроллёр уу дамжуулна. Микроконтроллёр толгойн хөдөлгөөнийг

тэргэнцрийн хөдөлгөөн болгох дохиог үүсгэж цахилгаан тэргэнцрийн хөдөлгүүрийг удирдана.




Зураг 3.1.3 Системийн бүтэц



Зураг 3.1.4 Цахилгаан тэргэнцрийн хийц

Машин сургалт нь системд тодорхой программчлалгүйгээр өгөгдлөөс автоматаар суралцах замаар сайжрах чадвартай хиймэл оюун ухаан (AI)-ы салбар юм. Машин сургалтын алгоритмууд нь аливаа мэдээллийн шинж чанарыг танин судалж, асуудлыг бие даан шийдвэрлэх чадвартай болгохыг зорьдог.


Нейрон сүлжээний оролтод 3 тэнхлэгийн хурдатгал a_x , a_y , a_z мөн 3 тэнхлэгийн гироскопын g_x , g_y , g_z болно.



Зураг 3.1.5 Нейрон сүлжээний загвар

Нейрон сүлжээний гаралтад цахилгаан тэргэнцрийн 5 төрлийн хөдөлгөөн (Зураг 3.1.5) байна.

Системийн программын алгоритмыг Зураг 3.1.6-д үзүүлэв.



Зураг 3.1.6 Программын алгоритм


3.1.1 Туршилтын үр дүн

Энэхүү судалгаагаар бид 5 төрлийн толгойн хөдөлгөөнийг 3 төрлийн нөхцөлд цуглуулсан болно. Тэргэнцрийн хөдөлгөөн бүрд 500 сургалтын өгөгдөл цуглуулсан ба нийт сургалтын өгөгдөл (Хүснэгт 3.1.1) 2500 байна.

Хүснэгт 3.1.1 Сургалтын өгөгдлүүд

x1	x2	x3	x4	x5	x6	y	Үйлдэл
-1.90	-0.57	10.52	0.01	0.04	-0.02	1	зогсох
-1.71	-0.23	10.64	-0.12	-0.23	0.91	1	зогсох
-2.15	-1.38	10.35	-0.07	-0.07	-0.06	1	зогсох
-1.82	-1.71	10.38	0	0.07	-0.05	1	зогсох
-2.54	-1.19	10.33	0.02	-0.03	-0.19	1	зогсох
-3.21	-1.93	7.96	1.62	1.39	0.23	2	урагш
-4.33	-0.38	8.31	-0.33	1.58	0.07	2	урагш
-4.17	-0.32	8.15	1.38	1.65	0.26	2	урагш
-2.95	-2.64	7.77	-0.71	2.16	-0.13	2	урагш
-3.72	-0.53	8.68	1	1.34	0.21	2	урагш
14.88	0.5	5.21	0.1	-0.6	-0.07	3	хойш
12.03	2.03	5.89	0.13	-1.26	0.1	3	хойш
11.34	1.84	6.18	0.58	-1.76	-0.03	3	хойш
8.93	1.48	5.86	0.39	-2.72	0.18	3	хойш
6.13	2.38	6.9	0.89	-2.05	0.22	3	хойш
-3.08	-9.87	7.34	-0.94	-0.4	-0.08	4	зүүн
-2.80	-10.89	6.94	-1.19	-0.43	-0.23	4	зүүн
-3.27	-9.97	7.24	-1.69	-0.44	-0.08	4	зүүн
-3.75	-6.1	7.41	-2.32	-0.19	-0.13	4	зүүн
-4.26	-8.56	6.9	-2.33	-0.44	-0.31	4	зүүн
-6.27	4.3	8.3	1.51	0.51	0.16	5	баруун
-4.76	2.97	8.64	1.75	0.51	0.02	5	баруун
-5.87	2.97	8.39	1.28	0.28	0.24	5	баруун
-5.89	3.26	8.14	1.71	0.45	0.27	5	баруун
-5.42	3.3	8.2	1.69	0.53	0.37	5	баруун

Python программын сан хэрэглэн өгөгдлүүдийн хамаарлыг графикаар илэрхийлэхийг зорьсон ба Зураг 3.1.7-д харахад хүний толгойн хөдөлгөөнөөр тэргэнцрийг удирдаж болох боломжтой гэдэг нь харагдах болно.



Зураг 3.1.7 Өгөгдлийн хамаарал

Туршилтын үр дүнд нейрон сүлжээний эхний давхаргын коэффициентууд нь :

$\{0.28, -3.93, -1.81, 1.95, -0.30, 0.48, 0.02\}$,
 $\{1.34, 1.00, -1.14, -0.66, -6.95, -6.20, -1.78\}$,
 $\{-0.05, 3.44, 1.41, -0.83, 0.29, -0.38, -0.01\}$,
 $\{1.65, 0.48, 1.49, -0.61, 7.55, -10.77, 1.56\}$,
 $\{-5.08, 1.88, 1.49, 2.67, 4.51, -17.21, 2.73\}$,
 $\{0.14, -3.96, -1.78, 1.98, -0.329, 0.75, 0.06\}$,
 $\{0.51, -1.03, -0.14, 4.66, 0.08, 0.06, -0.02\}$,
 $\{-11.96, 0.64, -0.34, 1.39, 2.16, 1.04, 0.83\}$,
 $\{0.56, 0.14, 1.28, 4.17, 0.36, 0.17, -0.03\}$,
 $\{0.37, -3.21, -2.41, 1.31, -0.41, 0.43, -0.16\}$

Нейрон сүлжээний хоёр дахь давхаргын коэффициентууд нь :

$\{-5.24, -0.93, -13.46, -3.94, -12.77, 15.04, -0.69, -4.73, 11.45, -4.00, -1.91\}$,
 $\{2.16, 3.15, -24.52, -1.37, -11.46, -13.71, 3.74, 3.22, -10.87, 0.87, 2.86\}$,
 $\{-2.17, -6.55, 2.33, 5.26, 1.37, 1.70, -7.16, -0.41, 0.57, 3.08, -2.28\}$,
 $\{-4.74, 0.97, 21.11, -7.31, -8.08, -3.10, 0.68, -4.99, 2.05, -5.80, 3.48\}$,
 $\{-5.79, 1.62, -6.37, -6.68, 17.68, 6.93, 2.06, -4.31, -9.78, -4.67, 0.48\}$ байна.


3.1.2 Дүгнэлт

Хийсэн ажлын хүрээнд Монголд байгаа тэргэнцэр болон гадаадад ашиглагдаг тэргэнцрүүдийн харьцуулсан судалгаа хийсэн. Зорьсон ажил нь Joystick гараар удирдах боломжгүй хүмүүст зориулан толгойн 5 төрлийн хөдөлгөөнийг машин сургалтаар сургаж цахилгаан тэргэнцрийг удирдах боломжтойг туршилтаар батлав. Машин сургалтаар 2500 өгөгдөл дээр сургасан ба оролтын 6 төлөв, 2 нууц давхаргатай мөн гаралтын давхарга 5 төлөвтэй байхаар нейрон сүлжээг загварчилсан болно. Бидний сургалт 97% -ийн нарийвчлалтай сурсан болно.

Энэхүү удирдлагын аргыг хэрэглэн хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохируулан сургах боломжтой юм. Ингэснээр хүн бүрд зориулсан онцгой удирдлагын систем үүсэх боломжтой юм.


3.2 Стерео хараа дээр тулгуурласан дөрвөн сэнстийн тогтворжуулах удирдлага

Тус судалгаагаар нисгэгчгүй олон сэнстийг зохион бүтээх төслийн хүрээнд хэрэгжүүлж буй туршилтын ажлын сүүлийн үеийн зарим үр дүнг танилцуулах болно. Хөдөлгөөнт робот зохион бүтээхэд тулгардаг гол асуудлуудын нэг нь байршил тогтоох юм. Роботын тэнхлэгийн хазайлтын өнцгүүд болон чиглэлийг тооцоолоход инерцлэг мэдрэгчийг өргөн хэрэглэдэг боловч бид хос камерыг ашиглан нэг объектын зургийг өөр өөр байрлалаас авах замаар стерео дүрсийг үүсгэж ийнхүү үүсгэсэн дүрсний мэдээллээс орон зайг хэмжиж болох, цаашилбал, дүрс боловсруулах аргыг хэрэглэн зүүн камерын дүрс (эхний байрлал) болон баруун камерын (хоёр дахь байрлал) дүрсний хоорондын хамаарлыг тодорхойлж ингэснээр объектын байрлалыг тогтоох зориулалт бүхий зарим геометрийн тооцооллыг хийсэн үр дүнг энэхүү судалгаагаар үзүүлэхийг зорилоо. Сүүлийн жилүүдэд гироскоп болон акселерометрийг ашиглан роботын хөдөлгөөний чигийг мэдрэх олон арга, алгоритмуудыг боловсруулан хэрэглэж байна. Гэвч уг мэдрүүрүүд нь өөрийн гэсэн сул талтай, алдааны хуримтлал үүсгэдэг, цахилгаан соронзон орны нөлөөнд өртөмтгий байдаг байна. Иймд бид эдгээр мэдрүүрийн оронд нисгэгчгүй олон сэнстэд стерео камерыг байрлуулж стерео дүрс боловсруулалтын аргыг хэрэглэх замаар хөдөлгөөний координатыг тодорхойлохыг зорьсон болно. Зураг 3.2.1-д системийн бүтцийг үзүүлэв.




Зураг 3.2.1 Системийн бүтэц

